



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2024 – 07 САР I ДУГААР 68

ГАРЧИГ

2–3 Бодлогын нийтлэл

4–7 Зохицуулалтын мэдээ

8–9 Байр суурь

10–12 Тогтвортой санхүүжилт

13–14 Компанийн засаглал, комплайнс

15–16 Финтек ба регтек

17–23 Судлаачийн индэр

24–25 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчээс зээл авахдаа юу анхаарах вэ?

26–27 Олон улсын зах зээлийн мэдээ

28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

ШИЛДЭГ 10: ДИЖИТАЛ БАНК

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ хэрэглэгчдэд чиглэсэн оновчтой үйлчилгээ санал болгодог оронцлог дижитал банкны талаар мэдээ мэдээлэл хүргэхээр бэлтгэлээ. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

Энэхүү жагсаалтад 2024 оны 2 дугаар улирлын шилдэг дижитал банкуудыг харуулав.

10. ALLY BANK

ally

Орлого: 2023 оны санхүүгийн жилд 15.97 тэрбум ам.доллар (Ally Financial)

Ажилчид: 11,000

Гүйцэтгэх захирал: Michael G. Rhodes

Үүсгэн байгуулагдсан: 2009

Мичиган мужийн Детройт хотод төвтэй Ally Bank нь онлайн банк, автомашины санхүүжилт, корпорацийн зээл, моргейжийн зээл, тээврийн хэрэгслийн даатгал зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. Ally нь шууд мөнгө байршуулах боломжийг санал болгодог бөгөөд 11 сая харилцагчидтай. 193 тэрбум долларын хөрөнгийг удирддаг бөгөөд “Харилцагч нэгт” гэсэн уриатай АНУ-ын шилдэг 25 санхүүгийн компанийн нэг бөгөөд Ally санхүүгийн хүртээмж, олон талт байдал, тэгш байдал, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхэд анхаарлаа хандуулдаг байгууллага юм.

9. VARO BANK

Varo

Орлого: 2022 оны санхүүгийн жилд 101 сая ам.доллар

Ажилчид: 500–1000

Гүйцэтгэх захирал: Colin Walsh

Үүсгэн байгуулагдсан: 2015

Сан Франциско хотод төвтэй Varo банк нь хувь хүний санхүүд төвлөрсөн АНУ-ын баруун эргийн шилдэг дижитал банк юм. 2015 онд байгуулагдсанаасаа хойш Varo нь Gallatin Point Capital, Harbourvest Partners, Warburg Pincus зэрэг олон хөрөнгө оруулагчдыг татсан. Мөн тус банк нь туршлагатай санхүүгийн мэргэжилтнүүдийг технологийн шинжээчидтэй хослуулан түргэн шуурхай бэлэн мөнгө авах, өндөр өгөөжтэй хадгаламжийн данс, автоматжуулсан хадгаламжийн хэрэгсэл зэрэг үйлчилгээнүүдийг санал болгодог.

Үргэлжлэлийг 15-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ШИНЖЭЭЧДИЙН БҮЛЭГ

Шууд утгаараа элдэв бодол санаагаар дүүрсэн сав багтаамж гэсэн хэллэг юм. Менежментэд энэ нь байгууллагад төрөл бүрийн асуудлаар зөвлөгөө, санаа өгдөг шинжээчдийн бүлгийг нэрлэдэг. Шинжээчдийн бүлэг ирээдүйг төсөөлөн гаргасан дүр зураг дээрээ үндэслэн урт хугацааны стратеги боловсруулахтай холбоотой судалгаа шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх гол үүрэгтэй байдаг.



THINK TANK

Literally, it means a tank filled with ideas. In management it is used as a metaphor to describe a group of experts who provide advice and ideas to organisations on different subject matters. The main function of a think tank is research, analysis and advice, usually related to developing longer-term strategies based on possible future scenarios developed by the think tank. (UNDP/LAO, 2001)

*Эх сурвалж: Засаглалын үзэл баримтлал,
нэр томъёоны тайлбар толь бичиг*

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, тулгамдаж буй асуудал, бэрхшээл, хөгжлийн бодлогын талаар төр, хувийн хэвшлийн дотоод гадаадын хөрөнгийн бирж, Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын арга хэмжээнд хөрөнгийн зах зээлийг тэлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

УИХ, Засгийн газраас санаачлан хэрэгжүүлж буй банкны салбарын реформ, төрийн өмчит компаниудын хувьчлал, “Зээлийн хүүг бууруулах стратеги” зэрэг бодлогын томоохон арга хэмжээний үр дүнд, мөн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх түүний эдийн засагт гүйцэтгэх үүргийг өсгөх, зах зээлийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх зорилгоор төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нягт хэрэгжүүлсний үр дүнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2024 оны 08 дугаар сарын байдлаар 12.3 их наяд төгрөгт хүргэсэн.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 175 компани болон хамтын хөрөнгө оруулалтын 3 сангаас нэр бүхий 30 компанийн зах зээлийн үнэлгээ 10.97 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 94.2 хувийг бүрдүүлж байна. Үнэлгээ хамгийн өндөр эхний таван компанийн зах зээлийн хувь хэмжээг авч үзэхэд дараах байдалтай байна.

- “ХААН банк” ХК 19.76 хувь
- “Худалдаа хөгжлийн банк” ХК 14.55 хувь
- “АПУ” ХК 11.05 хувь
- “Таван толгой” ХК 8.05 хувь
- “Голомт банк” ХК 6.29 хувь

Тус Хороо нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, хувьцаат компаниудыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, Хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасны дагуу компанийн болон биржийн цахим хуудсаар дамжуулан компанийн үйл ажиллагааны тайланг хагас жил, жилийн эцсийн байдлаар нийтэд мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын баримт материал, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласнаар хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлж, үнэт цаасны арилжаа, түүний хөрвөх чадвар нэмэгдэж, улмаар хууль журмаар хүлээсэн холбогдох үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой

аливаа хариуцлагын эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хорооны цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх, зөвлөх, хугацаатай үүрэг даалгавар хүргүүлэх гэх мэт арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн ажилладаг.

Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхийг оновчтой хэлбэрээр эдлүүлэх зорилгоор танхим болон цахим, хосолсон хэлбэрээр хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаар зохицуулалтын арга хэмжээг авсан ба 2024 онд 149 хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг ирүүлснээс 139 хурлын материалыг хянаж хариу хүргүүлээд байна. Мөн хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл, зохион байгуулах хэлбэр, байршлыг Хорооны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг ба сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох идэвхи жилээс жилд нэмэгдсээр байна.

Тус Хорооны 2024 оны 49 дүгээр тогтоолоор нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбогдуулан Хорооны 2020 оны 28 дугаар тогтоолд нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчид тарааж, ногдол ашиг хуваарилалтын тайлан ирүүлэхийг үүрэг болгосон. Үүний үр дүнд нийт 47 хувьцаат компани нь 2023 оны цэвэр ашгаасаа 14,366.1 сая ширхэг хувьцаанд ногдох 840.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан бөгөөд, мөн 2024 оны хагас жилд 2 хувьцаат компани ногдол ашиг тараах шийдвэрийг тус тус гаргасан. Үүний дагуу 2024 онд давхардсан тоогоор 5,298.7 сая ширхэг хувьцаанд ногдох 362.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 216,720 хувьцаа эзэмшигчид “ҮЦТХТ” ХХК–аар дамжуулан тараасан.

Өмнөх онд системийн нөлөө бүхий 5 арилжааны банкиг олон нийтэд хувьцаагаа санал болгож, нээлттэй хувьцаат компани болсонтой холбогдуулан 2022, 2023 онуудын жилийн эцсийн цэвэр ашгаас нийт тараагдах ногдол ашгийн хэмжээ хоёр дахин өссөн. Өмнөх онд тараагдсан 353.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийн хэмжээний 30.0 хувийг 2022 онд нээлттэй хувьцаат компани болсон “Голомт банк” ХК, “Төрийн банк” ХК дангаараа бүрдүүлж байсан бол 2023 онд нийт тараагдсан ногдол ашгийн 57.2 хувийг дангаараа системийн нөлөө бүхий 5 банк болох “Хаан банк” ХК (31.8%) “Худалдаа хөгжлийн банк” ХК (6.1%), “Голомт банк” ХК (8.5%), “Хас банк” ХК (5.0%), “Төрийн банк” ХК (5.9%)–ийн ногдол ашгийн хувийг тус тус дангаар эзэлж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдуулан ААНОАТТХ, ХХОАТТХ–уудад нэмэлт, өөрчлөлт оруулснаар 2024 оноос гадаадын хөрөнгө оруулагчийн албан татвар ногдох орлогыг дотоодын хөрөнгө оруулагчтай ижил тэнцүү, ялгаваргүй байдлаар суутган тооцох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчаас үл хамааран үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг 2024–2026 онд 90 хувиар, 2027–2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөх хуулийн зохицуулалт бий болсон.

Зохицуулалтын салбарын эрх зүйн шинэчлэлтийг хийж, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бодлогоор дэмжиснээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, тогтвортой, ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжиж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНХҮҮГИЙН САЛБАРЫН БЭЛГЭДЭЛ БОЛСОН БУХЫН ХӨШӨӨГ НЭЭЛЭЭ



Санхүүгийн салбарын бэлгэдэл болсон бухын хөшөөний нээлт боллоо. Нээлтийн арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн болон санхүүгийн салбарын байгууллага, холбоодын удирдлагууд оролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Дэлхий дахинаа эдийн засаг, санхүүгийн томоохон бүсүүдэд бухын дүрслэлийг хэрэглэж, улсынхаа эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хүч чадал, ололт, амжилтыг бэлгэшээдэг уламжлалтай. Энэхүү жишгээр манай улсын хувьд санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээлийнхээ өсөлт, хөгжлийг бэлгэшээж бухын дүрслэл бүхий хүрэл хөшөөг өөрийн орны ёс заншлыг шингээн урлаж бүтээсэн нь ийнхүү нээлтээ хийж байна. Ийнхүү санхүүгийн салбарт хүчин зүтгэж буй нийт ажилтан, энэ салбарт хувь нэмрээ оруулж буй хүн бүрд зориулж Улаанбаатар хотынхоо энэхүү хэсгийг “Санхүүчдийн талбай” гэж нэрлэж түүн дотроо салбарынхаа онцлогийг шингээсэн бухын хөшөөг босгосон нь томоохон үйл явдал болж байгаа бөгөөд нөгөөтээгүүр нийслэлд өнгө нэмж, иргэд, олон нийтийн амралт, чөлөөт цагаа өнгөрөөх газар нэгээр нэмэгдэж байгаад баяртай байна. Энэ жил Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 100 жил, Даатгалын салбарын 90 жилийн ой тохиож байгаагаас гадна Санхүүгийн зохицуулагч байгууллага ялангуяа хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ой тохиож байна. Энэ түүхэн хугацаанд хөгжлийн түвшин шинэ шатанд гарч, санхүүгийн олон шинэ бүтээгдэхүүнтэй, дэд бүтэц, технологи, хууль эрх зүйн хувьд олон улсын жишигт нийцсэн, хөрөнгийн зах зээлийн

үнэлгээ хөгжлийн түүхэнд хамгийн өндрөөр өсөж, FTSE Russell-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) ангилалд албан ёсоор багтсан шинэ өнгө төрх бүхий орчин үеийн зах зээл болж хөгжөөд байна. Хөрөнгийн зах зээлд гарч буй энэхүү өндөр өсөлт нь эдийн засгийг төрөлжүүлэх, тэр дундаа банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах банкны салбарын реформ, төрийн өмчит компаниудыг хувьчлах бодлогын реформ болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр биржийн бус зах зээлийг бий болгох, үнэт цаасны арилжааны шимтгэл, хураамжийг бууруулах, зах зээлийн зохицуулалтын орчныг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын цогц арга хэмжээний үр дүн билээ. Үүнд ялт ч үгүй төр, хувийн хэвшил, дэд бүтцийн байгууллагууд болон зах зээлд оролцогч бусад мэргэжлийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаа нөлөөлснийг онцлох нь зүйтэй байх. Түүнчлэн зах зээлийн өсөлт, хөгжилд Монгол Улсын иргэн бүрийн оролцоо ч чухал бөгөөд энэхүү хөшөөгөөрөө дамжуулж хүн бүр хөрөнгийн зах зээлийн талаар ойлголттой болж түүнийг дагаад санхүүгийн салбар маань илүү ихээр хөгжихийг ерөөж байна” гэсэн юм.

Санхүүгийн салбарын бэлгэдэл болсон энэхүү хүрэл хөшөөг уран бүтээлч Ж.Цолмонхүү, Д.Анхбаяр, Д.Ариунболд, Б.Лхагважав, Н.Саруул-Оргил, О.Жамьяантүвдэн болон Монголын урчуудын эвлэлийн гишүүн уран бүтээлчид бүтээсэн юм.

АЗИЙН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ХОЛБООНООС ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН УДИРДЛАГУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU), Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (МХЗХҮХ)-той хамтран хадгаламж, зээлийн хоршоодын удирдлагуудад сургагч багш бэлтгэх сургалт зохион байгууллаа. Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (ACCU)-ны гүйцэтгэх захирал Elenita V. San Roque, техник туслалцааны ахлах зөвлөх Ranjith Hettiarachchi нар удирдан явуулсан сургалтаар хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн орчинд хэрэгжиж буй хоршооллын зарчмууд, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, бодлого төлөвлөлт, хяналт



үнэлгээний талаар мэдээлэл олгосон юм. Мөн хадгаламж, зээлийн хоршооны олон улсын чадавхын үнэлгээний систем, хадгаламж, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх арга зүй зэрэг сэдвээр мэдээлэл, мэдлэг өгсөн бөгөөд Улаанбаатар хот, Орхон, Дархан, Говь-Алтай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод аймгийн нийт 15 ХЗХ-ны 17 гүйцэтгэх захирал, тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүд хамрагдлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл мөн энэ үеэр Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (АССУ)-ны төлөөллийг хүлээн авч уулзан, Монголын хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжил, цаашдын чиг хандлага, тулгамдаж буй асуудлууд, цаашдын хамтын ажиллагааныхаа талаар санал солилцов.

Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо (АССУ) нь Ази тив даяар бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой хадгаламж, зээлийн хоршоодыг хөгжүүлж, харилцаа холбоо, хамтын ажиллагааг дэмждэг байгууллага бөгөөд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (МХЗХҮХ) гишүүн байгууллага нь юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ТУРКИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Туркийн Хөрөнгийн бирж /Borsa Istanbul/-ийн гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Г.Гюзханыг хүлээн авч уулзлаа. Энэ үеэр Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар болон Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээнүүдийн талаар танилцуулсны зэрэгцээ хоёр орны хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлын талаар санал солилцсон юм. Мөн хоёр орны санхүүгийн салбар тэр дундаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцлаа. Тодруулбал, хоёр улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг бодлогоор дэмжихийн зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээний инновацыг хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татахад харилцан туслалцах, хил дамнасан санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох чиглэлд хамтарч ажиллахаар тогтлоо.

Турк нь Европ, Ази хоёр тивийг дамнан тогтсон олон улсын зам харилцааны гол орон бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг Европ тивтэй холбох, олон улсад таниулан сурталчлах, гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон олон улсын зах зээлээс нэмэлт эх үүсвэр татах, хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм.

“ХӨРӨНГӨ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖ” САЛБАР ХУРАЛДААН БОЛЛОО

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, тулгамдаж буй асуудал, бэрхшээл, хөгжлийн бодлогын талаар жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Монголын эдийн засгийн чуулган” өнөө жилийн хувьд “Go Mongolia” урианы доор энэ өдрүүдэд болж өнгөрөв. Чуулганы “Хөрөнгө санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулалтын боломж” сэдэвт салбар хуралдааныг Санхүүгийн зохицуулах хороо зохион байгуулсан бөгөөд хуралдаанаар төр, хувийн хэвшлийнхэн, дотоод, гадаадын хөрөнгийн бирж, санхүүгийн байгууллагын төлөөллүүд Монголын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын арга хэмжээний талаар хэлэлцлээ. Мөн Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг тэлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хүрээнд тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэх гарц, гаргалгааны талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.


“Монголын эдийн засгийн чуулган” нь хөрөнгийн зах зээлийг гадаад, дотоодын томоохон зочид, төлөөлөгчдөд



сурталчлан танилцуулж, дотоодын зах зээлийг олон улсын зах зээлтэй холбоход чухал ач холбогдолтой арга хэмжээ юм. Хуралдааны үр дүнд Монголын хөрөнгийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх буюу Монгол Улсад нэн шаардлагатай гадаад, дотоодын, урт хугацааны хөрөнгө оруулалт, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх хүрээнд баримтлах бодлогыг хамтран тодорхойлж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх тодорхой бодлогын чиглэлүүд гарлаа.

ТОРОНТОГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ ХАМТРАН ВЕБИНАР ЗОХИОН БАЙГУУЛАВ


Санхүүгийн зохицуулах хорооноос Торонтогийн Хөрөнгийн Бирж, Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайдын яам, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо болон



Capital Markets Mongolia байгууллагатай хамтран “Opportunities on Toronto Stock Exchange: Navigating listings & Regulations” вебинарыг зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан вебинарыг нээж хэлсэн үгэндээ “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох, гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд оролцох идэвх сонирхлыг нэмэгдүүлэх, дотоодын

аж ахуйн нэгжүүд шаардлагатай урт хугацааны санхүүжилтээ олон улсын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд нь бодлогоор дэмжлэг үзүүлж, татвар, эрх зүйн зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх нь бидний нэн тэргүүний зорилт юм. Тиймдээ ч биржид бүртгэлтэй компаниудыг Монголын болон гадаадын хөрөнгийн бирж дээр давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах, хувьцаат компаниудын тайлан, мэдээ, мэдээллийг англи хэл дээр гаргах, түгээх, хөрөнгө



оруулагчидтай харилцах харилцааг сайжруулах зэрэг чиглэлд анхаарч ажиллаж байна.” гэдгийг онцолсон юм. Тус вебинараар ҮЦГ-ын дарга Б.Дөлгөөн Монголын хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын төлөвийн талаар танилцуулахын сацуу Торонтогийн хөрөнгийн биржийн Европ, Ойрх Дорнод, Африкийн бүс хариуцсан Бизнес хөгжлийн захирал ноён Graham Dallas давхар бүртгэл, гадаадын үнэт цаас гаргагчид тавигдах нөхцөл, шаардлага, бүртгэлийн онцлох зохицуулалтууд болон тайлагналын шаардлагын талаар банк, санхүү, хөрөнгийн зах зээлийн нийт оролцогчид болон олон улсад үнэт цаас гаргах сонирхолтой аж ахуйн нэгж, компаниудад мэдээлэл өгсөн юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох хүрээнд цаашид энэ төрлийн вебинарыг цуврал болгон зохион байгуулахаар ажиллаж байна.

Та доорх линкээр тус вебинарыг үзэх боломжтой. <https://youtu.be/oWDFe7jMBxw?feature=shared>

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ МЭРГЭЖИЛТНҮҮД ТАНГАРГАА ӨРГӨЛӨӨ



Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах 148 мэргэжилтэн тангаргаа өргөж, эрхээ гардан авлаа.

Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороо хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог өсгөх, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварыг сайжруулж, хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэхээр бодлого зохицуулалтын цогц арга хэмжээг үе шаттайгаар, цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өнөөдрийн байдлаар 11.14 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь зах зээлийн хөгжлийн суурь үзүүлэлтүүд өсөж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн зах зээлд итгэх итгэл, оролцоо нэмэгдэж байгааг харуулж байна. Энэ удаагийн сургалтаар мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан биржийн зуучлагч /брокер/-ийн чиглэлээр эрх олгож байна. Энэ хууль нь өнгөрсөн оноос мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулж уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн чиглэлээрх эрх олгох сургалтыг явуулах шаардлагатай болсон. Түүнчлэн УИХ-аас баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр өөрийгөө зохицуулах байгууллага буюу мэргэжлийн холбоонд мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, үргэлжилсэн сургалт зохион байгуулах чиг үүргийг тусгаад байна” гэдгийг онцолсон юм.

Энэ удаагийн үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах шалгалтад 148 иргэн тэнцсэнээс 17 иргэнд үнэт цаасны зах зээл дээр үнэт цаасны зуучлалын ажил, үйлчилгээ явуулах эрхийг, 44 иргэнд үнэт цаасны зах зээл дээр хөрөнгө оруулалтын ажил, үйлчилгээ явуулах эрхийг, 44

мэргэжилтний эрхийг аттестатчилахаар шийдвэрлэсэн. Мөн 43 иргэнд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны үнэт цаасны зуучлалын ажил, үйлчилгээ явуулах эрхийг олгохоор болсон. Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай салбаруудыг хөгжүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулж, мэргэшүүлэх зорилгоор Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран 2011 оноос эхлэн сургалтыг зохион байгуулж ирсэн. Өнгөрсөн хугацаанд 39 удаагийн эрх олгох, аттестатчилах шалгалтыг зохион байгуулж нийт 3559 мэргэжилтэнд хөрөнгийн зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгосон бөгөөд эрх нь хүчин төгөлдөр хэвээр байгаа 1,732 мэргэжилтэн ажил, үйлчилгээ явуулж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ КАМБОЖИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНГИЙН ЯАМНЫ ТӨЛӨӨЛӨГЧИД ТАНИЛЦЛАА

Камбож Улсын Эдийн засаг, сангийн яамны орлогч сайд ноён Н.Е. Pen Thirong-оор ахлуулсан төлөөлөгчид Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ хорооны дарга Д.Баярсайхан болон холбогдох газрын дарга нартай уулзаж хамтын ажиллагаа болон туршлага солилцох талаар санал солилцлоо. Энэ үеэр төлөөлөгчдөд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын томоохон арга хэмжээний талаар танилцуулав. Тэр дундаа хүртээмжтэй, ногоон санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, үр дүн, туршлагаас онцлон танилцуулаад цаашид тогтвортой ногоон санхүүжилтийг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудынхаа талаар мэдээлэл өгч харилцан санал солилцов. Эдгээр төлөөлөгч нь НҮБ-ИЙН Хөгжлийн хөтөлбөртэй хамтран “Монгол Улсын Санхүүгийн салбарын хөгжил, өрийн удирдлага, ногоон бонд, Үндэсний санхүүжилтийн нэгдсэн стратеги (INFF)-ийн туршлага судлах” ажлын хүрээнд манай улсад ажиллаж байгаа бөгөөд энэ үеэр ийнхүү Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ удирдлагуудтай уулзалт хийж санал солилцсон юм.

БАЙР СУУРЬ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН САЛБАРЫН “MONGOLIAN JEWELLERY&METAL EXPO, FORUM” 2024 АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Н.Энхтуяа



Танд энэ өдрийн мэнд хүргэе. Ярилцлагаа салбарын өнөөгийн байдал болон бодлого зохицуулалтын талаар эхлүүлэе.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар нь төрийн хяналт зохицуулалтад хамрагдаад өдгөө 4 жил өнгөрсөн байна. Манай салбарын хувьд энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдээс гадна иргэдэд тусгай зөвшөөрөл олгогдоороо онцлогтой.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны эхний хагас жилийн байдлаар 53 хуулийн этгээд, 453 иргэнд дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоод байна.

Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбар нь салбар дундын зохицуулалттай гэдгээрээ онцлогтой. Тус салбарт үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид, үнэт металл, үнэт болон эрдэнийн чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдээс гадна соёлын өвийг тээгч, түгээн дэлгэрүүлэгчид болох уран дархчууд мөн хамаардаг.

Тийм ч учраас алсыг харсан, олон улсын жишиг, сайн туршлага болон үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн, судалгаа шинжилгээнд тулгуурласан бодлогыг тодорхойлж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад салбарын оролцогчид болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо нэн чухал ач холбогдолтой юм.

Санхүүгийн зохицуулах хорооны хувьд салбарын оролцогчдын уялдаа холбоог хангах, тэднийг бодлого зохицуулалтаар дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2022 оноос эхлэн өдгөө 3 дахь жилдээ “Mongolian jewellery&metal expo, forum” арга хэмжээг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.

“Mongolian jewellery&metal forum” арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү.

Энэ жилийн форумгаар “Асуудал, Шийдэл, Боломж” ерөнхий сэдвийн хүрээнд “Үнэт металлын салбар дахь олборлолт ба боловсруулалт”, “Үнэт металлын салбар дахь үйлдвэрлэл, үйлчилгээ”, “Үнэт металлын салбар дахь арилжаа, хөгжих боломж” гэсэн 3 дэд хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлэгт манай байгууллагаас гадна Соёлын яам, Нийслэлийн Соёл, урлагийн газар, Оюуны Өмчийн Газар, Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар, Монголбанкны төлөөллүүд оролцож, салбарын оролцогчдоос дэвшүүлсэн санал санаачилга, тулгамдсан асуудлыг сонсож, асуудал, шийдлийн талаар санал солилцож, гарц гаргалгааг эрэлхийлсэн үр дүнтэй хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн юм.

Мөн форумын үеэр Санхүүгийн зохицуулах хороо болон “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний холбоо”-д Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарыг хөгжүүлэх,

нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх, зах зээлийн мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, мэргэжлийн хариуцлагыг бий болгох, зах зээл дэх шударга өрсөлдөөнийг бүрдүүлэх төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Харилцан ойлголцлын санамж бичиг” үзэглэлээ.

Таны дурдсанчлан салбарын нэгдсэн үзэсгэлэн, экспог өдгөө 3 дахь жилдээ зохион байгуулсан байна. Тэгвэл энэ жилийн хувьд өмнөх жилүүдээс онцлог зүйл нь юу байсан бэ?

Энэ жилийн үзэсгэлэнгийн арга хэмжээнд БНСУ–ын улсын жижиг дунд үйлдвэрлэлийн холбоо, БНХАУ–ын үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн төлөөлөгчид болон гадаад дотоодын олон зочид төлөөлөгчид оролцож, зохицуулалттай этгээдүүдийн хосгүй үнэт бүтээлүүдтэй танилцсан.

Мөн экспоны үеэр зохион байгуулагдсан соёлын биет өв болох уран дархчуудын уран хийцлэл бүхий, хосгүй үнэт бүтээлүүд нь хэрэглэгчдийн сонирхлыг хамгийн их татсан юм.

Салбарт зохион байгуулагдсан томоохон арга хэмжээний талаар мэдээлэл хүргэсэн танд баярлалаа. Ярилцлагаа гадаад хамтын ажиллагаа, сайн туршлагын талаар үргэлжлүүлье.

Баярлалаа. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн салбар нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллагаас Монгол улсыг саарал жагсаалтад оруулсантай холбогдуулан тус байгууллагаас ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх төрийн бодлогын хүрээнд хяналт зохицуулалтад хамаарсан гэдгийг та бүхэн мэднэ.

Тийм учраас салбарын бодлогыг тодорхойлоход улс орнуудын сайн жишгийг судлах санал солилцох нь маш чухал.

Миний бие энэ оны 5 дугаар сард Санхүүгийн зохицуулах хороог төлөөлөн Франц улсын нийслэл Парис хотноо зохион байгуулагдсан ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын хамгийн том чуулган болох “Хариуцлагатай ашигт малтмалын нийлүүлэлт сүлжээ” сэдэвт форумд оролцоод ирлээ.

Тус форумд манай байгууллагаас гадна Монголбанкны төлөөлөл болон “planetGOLD” төслийн төлөөлөгч нар оролцож, 5 өдрийн турш алтны бичил уурхайн санхүүгийн хүртээмжийг сайжруулах, алтны нийлүүлэлтийн сүлжээг ил тод, хариуцлагатай болгох чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Мөн форумын үеэр Эдийн засаг, хамтын ажиллагааны

хөгжлийн байгууллага, Дэлхийн алтны зөвлөл, Аргор Хереаус зэрэг олон талуудтай уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх, мэдээлэл солилцох, мэдлэг түгээх, оролцогч талуудыг чадавхжуулах, хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцлоо.

Тантай ярилцах үеэр төр болон төрийн бус байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааны талаар ихээхэн дурдлаа. Энэ талаар мэдээлэл өгнө үү.

Тийм ээ. Салбарын хувьд тулгамдаж буй асуудлууд маш их байна. Иймд салбарын оролцогчдын уялдаа холбоог хангахад төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал юм.

Иймд салбарын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, стандарт тогтоох, бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын код, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр болон эдийн засгийн код зэрэгт санал өгөх, судалгаа шинжилгээ хийх, статистик мэдээллийн нэгдсэн бааз үүсгэх зэрэг арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай уулзаж, салбарын хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох, үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтод байх, салбарын ангилалд дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах, салбарын онцлогт тохирсон сургалтуудыг хийх зэрэг тулгамдаж буй олон асуудлаар цаашид хамтран ажиллахаар боллоо.

Мөн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд салбарт нийтийн ашиг сонирхол, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, стандартчилал, сорьцын хяналтын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор Стандарт, хэмжил зүйн газрын удирдлагуудтай уулзлаа.

Тус уулзалтаар хамтын ажиллагааг өргөжүүлэн, үнэт металл, эрдэнийн чулуу тэдгээрээр хийсэн эдлэлийн олборлогчид, үйлдвэрлэгчид, арилжаалагчдын сорьцын хяналт, сорилтоор дамжсан бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх техникийн хороо байгуулж ажлын хэсэг томилох, холбогдох статистик мэдээллийг харилцан солилцлоо.

Мөн энэ оны 04 дүгээр сард Монгол Улсын Их Хурлаас “Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай” хуулийг баталсан бөгөөд тус хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс эхэлж дагаж мөрдөх тул мэргэжлийн холбоотой илүү өргөн хүрээнд хамтран ажиллах эрх зүйн үндэс бүрдэж байна гэж харж байна.

Ярилцсанд баярлалаа. Танд амжилт хүсье.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКААР ДАМЖУУЛДАГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН САНГУУД

ТоС Холбооны Монголын ногоон санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааны хэсгээс

Ази номхон далайн төсөл бэлтгэх сан (АРЗФ)

АРЗФ нь Ази, Номхон далайн бүсийн дэд бүтцийн хөгжлийн түвшнийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн чанарыг сайжруулах зорилготой олон хандивлагчийн итгэлцлийн сан юм. АРЗФ-ийн гол зорилго нь хөгжиж буй гишүүн орнуудын Засгийн газар болон тэдгээрийн төрийн секторын агентлагуудад хувийн хэвшлийн оролцоотой дэд бүтцийн төслүүд, тэр дундаа төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP) хэлбэрээр хувьчлах замаар дэд бүтцийн төслүүдийг бэлтгэж, бүтэцжүүлэх, дэлхийн зах зээлд гаргахад туслах явдал юм.

АРЗФ нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Чадавч бэхжүүлэхтэй холбоотой туслалцаа үзүүлэх, тэр дундаа хөгжиж буй гишүүн орнуудад бодлого, хууль тогтоомж, дүрэм журам болон байгууллагын туршлагыг шинэчлэх, сайжруулах;
- Одоо хэрэгжиж буй төслүүдэд төслийн хяналт тавих, бүтцийн өөрчлөлт хийх зэрэг гүйцэтгэлийн туслалцаа үзүүлэх.

Сангийн хөрөнгө оруулалтын хэмжээ: 73 сая ам.доллар

Дэмжлэг үзүүлэх зорилго: Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллага, дэд үндэсний хэмжээний төрийн байгууллага.

Гол зорилтот салбар, чиглэл:

- Эрчим хүч
- Тээвэр
- Хот байгуулалт
- Нийгмийн дэд бүтэц

Уур амьсгалын зорилт: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах ба тэдгээрийн давхцал үйл ажиллагаанууд

Санхүүжилтийн механизм: Буцалтгүй тусламж.

Азийн цэвэр эрчим хүчний сан (ACEF)

ACEF санг Япон улс Азийн тогтвортой хөгжлийг дэмжих санаачилгын хүрээнд байгуулсан ба Цэвэр эрчим хүчний санхүүжилтийн түншлэлийн сан (CEFPF)-гийн нэг хэсэг юм. Тус сан нь хөгжиж буй гишүүн орнуудын сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй технологи ашиглан хүлэмжийн хийг бууруулах хүчин чармайлтыг дэмждэг.

Сангийн хөрөнгийн хэмжээ: 5.23 сая ам.доллар хуваарилагдана.

Санд хөрөнгө оруулагч: Япон

Дэмжлэг үзүүлэх зорилго: Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллага

Гол зорилтот салбар, чиглэл:

- Эрчим хүчний хэмнэлт
- Сэргээгдэх эрчим хүч

Уур амьсгалын зорилт: Сааруулах.

Санхүүжилт олгох хэлбэр: Буцалтгүй тусламж, биет бус хувь нэмэр

Өргөдөл хүлээн авах хугацаа: Өргөдлийг жилд нийт 6 удаа хүлээж авдаг.

Хугацаа нь: 1-р сарын 31, 3-р сарын 31, 5-р сарын 31, 7-р сарын 30, 9-р сарын 30 болон 11-р сарын 30.

Хамтын санхүүжилтийн шаардлага: Байхгүй

Жендерийн шалгуур: Сангийн үйл ажиллагааг АХБ хариуцдаг тул санхүүжилт олгох төслүүд нь АХБ-ны Жендерийн бодлоготой уялдах шаардлагатай.

ХХЯ бууруулах шаардлага: Байгаа. ХХЯ-ын тооцоолол шаардлагатай.

Төслийн мөчлөг: Хэрэглэгчийн хэлтсээс төслийн саналыг CEFPF-ийн өргөдлийн маягт болон АХБ-ны стандарт баримт бичгийн дагуу сангийн менежерт явуулна. Цэвэр эрчим хүчний ажлын хэсэг нь CEFPF-ийн санхүүжилтийн түншүүд болон АХБ-ны хооронд тохиролцсон загвар, мониторингийн тогтолцоог удирдлага болгон хэрэгжүүлэх удирдамжид үндэслэн төслийн саналыг хянаж, дэмжинэ. Уур амьсгалын өөрчлөлтийн удирдах хороо нь сонгогдсон төсөлд нөөцийн хуваарилалтын эцсийн шийдвэрийг гаргана. CEFPF-аас санхүүжилт хуваарилагдсаны дараа АХБ-ны стандарт журмын дагуу процесс үргэлжилнэ. Азийн тогтвортой хөгжлийг нэмэгдүүлэх санаачилгын эхний тулгуурын хүрээнд Японы тусламжийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэн тэргүүнд анхаарч ажиллана.

Уур амьсгалын өөрчлөлтийн сан (CCF)

CCF нь уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврыг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор хөгжиж буй гишүүн орнуудад илүү их хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх зорилгоор 2008 оны 5 дугаар сард байгуулагдсан. CCF нь АХБ-ны үйл ажиллагаанд уур амьсгалын үйл ажиллагааг нэвтрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Стратеги 2030-ын үйл ажиллагааны гурав дахь тэргүүлэх чиглэл болох уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, уур амьсгал, гамшигт тэсвэртэй байдлыг бий болгох, байгаль орчны тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Сангийн хөрөнгийн хэмжээ: 98 сая ам.доллар.

Санд хөрөнгө оруулагч: АХБ Дэмжлэг үзүүлэх зорилго: Төсөл хөтөлбөр бэлтгэх, хэрэгжүүлэх.

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллага.

Уур амьсгалын зорилт: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах ба тэдгээрийн давхцал үйл ажиллагаанууд.

Гол зорилтот салбар, чиглэл:

- Хот;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах;
- Ойн аж ахуй ба газар ашиглалт;
- Аж үйлдвэр ба дэд бүтэц;
- Сэргээгдэх эрчим хүч;
- Тээвэр.

Санхүүжилт олгох хэлбэр: Буцалтгүй тусламж.

Санхүүжилтийн хэмжээ: Нэг төсөлд олгох санхүүжилтийн дээд хэмжээ 5 сая ам.доллар.

Өргөдөл хүлээн авах хугацаа: Өргөдлийг жилд нийт 6 удаа хүлээж авдаг.

Хугацаа нь: 1-р сарын 31, 3-р сарын 31, 5-р сарын 31, 7-р сарын 30, 9-р сарын 30 болон 11-р сарын 30

Хамтын санхүүжилтийн шаардлага: Шаардлагагүй.

ХХЯ бууруулах шаардлага: Байгаа, ХХЯ-ын тооцоолол шаардлагатай.

Ирээдүйн нүүрстөрөгчийн сан (FCF)

FCF нь АХБ-наас байгуулж, удирддаг итгэлцлийн сан юм. Энэхүү сан нь Цэвэр хөгжлийн механизм (ЦХМ)-ийн төслүүдэд санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлдэг АХБ-ны хэрэгжүүлж буй Нүүрстөрөгчийн зах зээлийн хөтөлбөрийн (CMP) бүрэлдэхүүн хэсэг юм.

FCF нь дараах зорилготой:

- Эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон хөгжиж буй гишүүн орнуудад 2012 оноос хойш хэрэгжиж буй хүлэмжийн хийг (ХХ) бууруулах урт хугацааны үр өгөөжтэй бусад төслүүдийг дэмжих.
- 2012 оноос хойш хүлэмжийн хийг бууруулах зорилт, бодлого баримталж буй оролцогчдод баталгаажсан ялгаралтын бууралт (CER) болон баталгаажуулж болохуйц ялгаралтын бууралт (VERs) –д тасралтгүй нэвтрэх боломжийг олгох замаар туслах.
- Хүлэмжийн хийг бууруулах төслийн анхны хөрөнгийн саад бэрхшээлийг бууруулах замаар нүүрстөрөгч бага ялгаруулдаг технологиудын уламжлалт хувилбаруудаас хямд үнэ, сонирхол татахуйц байдлыг нэмэгдүүлэх. Санд хөрөнгө оруулагчид: Бельги, Финланд, БНСУ, Швед, Хувийн секторын 2 байгууллага

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллага Санхүүжилт олгох хэлбэр: Зээл, өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалт, батлан даалт

ХХЯ бууруулах шаардлага: ХХЯ-ын тооцоолол шаардлагатай.

Гол зорилтот салбар, чиглэл:

- Эрчим хүчний хэмнэлт;

- Аж үйлдвэрийн технологи;
- Нийлүүлэлтийн талын технологи (e.g., upgrade of generation equipment);
- Нийтийн тээвэр болон тээврийн хэрэгслийн үр ашиг;
- Сэргээгдэх эрчим хүч;
- Багаас дунд хэмжээний голын урсацын усан цахилгаан станц;
- Биомасс;
- Салхины эрчим хүч;
- Нарны эрчим хүч;
- Газрын гүний дулааны эрчим хүч;
- Метаныг барих, ашиглах;
- Нүүрсний уурхайн метан;
- Хатуу хог хаягдал, бохир ус цэвэрлэх.

Хамтын санхүүжилтийн шаардлага: Технологийн зардлыг нөхөх буцалтгүй тусламж нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг бөгөөд ихэвчлэн технологийн нийт зардлын тодорхой хувийг олгодог.

Усны санхүүжилтийн түншлэлийн сан (WFPF)

WFPF нь АХБ-ны усны санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөгжлийн түншүүдээс нэмэлт санхүүгийн болон мэдлэгийн нөөцийг дайчлах зорилгоор 2006 оны 12-р сард байгуулагдсан сан юм. Анхны зорилго нь АХБ-ны 2006–2010 онд дэвшүүлсэн зорилтот үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн бөгөөд АХБ-ны 2011–2020 оны Усны ашиглалтын төлөвлөгөөг батлагдсаны дараагаар 2020 он хүртэл сунгагдсан. АХБ-ны 2030 хүртэлх стратегид хэрхэн хувь нэмэр оруулахыг тодорхойлсон “Усны салбарын хүрээ 2021–2030: Усны аюулгүй байдал ба тогтвортой Ази номхон далайн бүс нутаг” баримт бичгийг удиртгал болгон WFPF нь 2021 оноос үргэлжлүүлэн АХБ-ны усны салбарын үйл ажиллагааг үргэлжлүүлэн дэмжихээр болсон.

Санд хөрөнгө оруулагчид: Австрали, Австри, Bill & Melinda Gates сан, Голланд, Норвеги, Испани, and Швейцарь.

Сангийн хөрөнгийн хэмжээ: 2020 оны 12-р сарын байдлаар 116.401 сая ам.доллар.

Дэмжлэг үзүүлэх зорилго: Төсөл хэрэгжүүлэх орчны бүрдүүлэх, институтийн чадавх бүрдүүлэх, төсөл ба хөтөлбөр хэрэгжүүлэх

Хамрах хүрээ: Үндэсний хэмжээний төрийн байгууллагууд.

Уур амьсгалын зорилт: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох.

Гол зорилтот салбар, чиглэл:

- Ус буюу тогтвортой нөөц;
- Нийтийн ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээ;
- Хөдөө аж ахуй болон эдийн засагт үр ашигтай ус;
- Устай холбоотой эрсдэлийг бууруулах.

Чиглүүлэгч зарчмууд:

- Тогтвортой, дасан зохицох чадварыг бий болгох;
- Хүртээмжтэй, жендерийн эрх тэгш байдлыг дэмжих;
- Тогтвортой байдлыг эрхэмлэх;
- Засаглалыг сайжруулж, санхүүжилтийг хурдасгах;
- Инновац, технологийн дэвшлийг дэмжих.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

Цалин урамшууллын хороо нь компанийн гүйцэтгэх захирал, удирдлагын баг зэрэг компанийн эрх бүхий албан тушаалтны цалин хөлс, урамшууллыг тогтоох үүрэг бүхий компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дэргэдэх хороо юм.

Эрх бүхий албан тушаалтны урамшууллын асуудлыг шийдвэрлэхэд олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай хэдий ч хувьцаа эзэмшигчдийн хүлээлтэд эерэг үр дүн үзүүлэхийн тулд өндөр гүйцэтгэлтэй удирдах ажилтнуудыг урамшуулах нь чухал.

Сүүлийн жилүүдэд эрх бүхий албан тушаалтны, ялангуяа гүйцэтгэх захирлын цалин урамшуулалтай холбоотой үзэл бодлын зөрчил, маргаан ихээр гарч байгаа нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байна.

Цалин, урамшуулал нь гүйцэтгэлийн үр дүнтэй хамааралтай байх ёстой бөгөөд энэхүү бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангах нь Цалин урамшууллын хорооны үндсэн зорилго аж.

Цалин, урамшууллын хорооны үүрэг

Цалин, урамшууллын хороо нь хувьцаа эзэмшигчдийн хүлээлтэд эерэг нөлөө үзүүлэхүйц гүйцэтгэлтэй, удирдах албан тушаалтны сонирхлыг татахуйц цалин урамшууллын зохистой бодлоготой байж, дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтан болон ахлах түвшний ажилтнуудын цалин, урамшууллаас гадна тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг хянах;

ТУЗ-ийн бүрэлдэхүүн болон гүйцэтгэх удирдлагын ажлаас халагдсаны нөхөн төлбөрийг шийдвэрлэх;

Компанийн цалин урамшууллын бодлого нь ашиг сонирхлын зөрчилгүй, шударга, ил тод хэрэгжиж буйд хувьцаа эзэмшигчдийн итгэлийг төрүүлэх.

Цалин, урамшууллын хорооны бүрэлдэхүүн

Хорооны бүрэлдэхүүнийг (ихэвчлэн) шийдвэр гаргахад нөлөөлж болохуйц дотоод, гадаад хүчин зүйлс, тэр дундаа дээр дурдсан асуудал болон бизнесийн ёс зүй, байгууллагын соёл зэрэг өндөр түвшний мэдлэг, ур чадвартай, бие даасан, хараат

бус гишүүдээр бүрдүүлэх нь зохистой бөгөөд удирдлагын цалин, урамшуулалтай холбоотой ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагатай.

Түүнчлэн, компанийн цалин хөлсний талаарх баримталж буй бодлого, хандлага, ажлаас халах гэрээний нөхцөл, гэнэтийн тохиолдлыг зохицуулах тусгай зохицуулалт болон удирдлагад өгч ирсэн цалин урамшууллын талаар ойлголттой байх нь чухал.

Цалин, урамшууллыг тогтоох

Удирдах ажилтнуудын үндсэн цалинг тогтоохдоо зах зээл дээрх ижил төстэй компаниудын практик жишигт суурилдаг. Гүйцэтгэх захирлын урамшууллыг гүйцэтгэлийн үр дүнтэй холбох ба хувьцаа эзэмшүүлэх сонголтыг олгох нь зөв.

Тухайн салбарын онцлог, компанийн хэмжээ, гүйцэтгэлийн түвшин, салбар, газар зүйн байршил, мөнгөний урсгал, гүйцэтгэлийн үнэлгээ зэрэг нь цалин урамшуулалд нөлөөлөх хүчин зүйлс юм.

Гүйцэтгэх удирдлагын цалинд бизнесийн хүрээллээс гадна бусад оролцогч талууд анхаарал тавьж байдаг тул шударга, ил тод байлгах нь Цалин, урамшууллын хорооны үүрэг чухал.

Иймд зах зээл дээрх ашиг сонирхлын бүлгүүд болон оролцогч талуудын талаар нарийн ойлголттой, тухайн салбарын цалин, урамшууллын талаарх мэдээлэлтэй байх нь цалин хөлсний зохих түвшин, үндэслэлийг тогтооход ач холбогдолтой.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын асуудалд анхаарал хандуулах нь нэмэгдэж байгаатай зэрэгцэн өрсөлдөхүйц цалин, урамшуулал болон шударга, тэнцвэртэй байдлыг бий болгох шаардлага Цалин, урамшууллын хороонд тавигдаж байна. Цалин, урамшуулал, нөхөн төлбөрийн асуудал салбар бүрд ялгаатай байдаг тул энэ талаар ТУЗ-д зөвлөгөө өгөх тусгай хороотой байх нь зүйтэй.

Ашиг сонирхлын зөрчилгүй, ТУЗ-ийн аль ч гишүүн Цалин, урамшууллын хороонд ажиллах боломжтой ч дор хаяж нэг гишүүн нь цалингийн төсөв боловсруулж байсан туршлагатай байх нь зөв.

Цалин, урамшууллын хорооны бусад үүрэг

- ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх удирдлагын ажиллах нөхцөл, ажлын байрны тодорхойлолтыг хянах;
- Ахлах түвшний албан тушаалтнуудын цалингийн бүтэц, урамшууллын бүртгэл хөтлөх;
- Эрх бүхий албан тушаалтнуудад нөхөн олговор олгох, ажлаас халах нөхөн төлбөрийн хэмжээг нарийвчлан тогтоох;
- Гүйцэтгэх удирдлагын компанийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь шударгаар үнэлж байгаад хяналт тавих;
- Гүйцэтгэх удирдлагын цалин хөлсийг ашиг сонирхлын зөрчилгүй, шударга, ил тод шийдвэрлэн олгож буйд хувьцаа эзэмшигчдийн итгэлийг төрүүлэх.

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, хүлээлтийг хангаж ажиллахын тулд дараах багц бүхий цалин урамшууллыг гүйцэтгэх удирдлагад санал болгож байна:

- **Тогтмол цалин хөлс:** Гүйцэтгэх удирдлагын хөдөлмөрийн гэрээний нөхцөлд үндэслэх ба ихэвчлэн үндсэн цалин, тэтгэвэр, нэмэлт тэтгэмжээс бүрдэнэ. Гүйцэтгэлийн үнэлгээ үүнтэй холбоогүй бөгөөд тогтмол цалин хөлс нь ерөнхийдөө зах зээл дээрх ижил төрлийн салбарын үзүүлэлтэд суурилдаг. Хэрэв гүйцэтгэх захирал гадаад улсаас уригдан ирэх, эсхүл гадаад улсын иргэн байх нөхцөлд тухайн улсын буюу байнга оршин суудаг улсын түвшнийг харгалзан үзэх шаардлагатай.

- **Мөнгөн урамшуулал:** Маш сайн гүйцэтгэлийн үнэлгээтэй ажилласан гүйцэтгэх захирлуудад олгож болох бөгөөд ирээдүйд компанийн хувьцааг эзэмшүүлэхээр амлалт өгч болдог.
- **Хувьцааны опцион:** Энэ нь компанийн тодорхой тооны хувьцааг ирээдүйд тогтсон хугацаанд, тогтоосон үнээр эзэмшүүлэх эрхийг хэлнэ. Компанийн үнэ цэнийг өсгөснөөр хувьцааны үнэ өсөж, энэ нь гүйцэтгэх захирал сайн ажиллах нэг төрлийн хөшүүрэг болдог. Нэгэнт хувьцаа эзэмшигч болсон тохиолдолд гүйцэтгэх захирлын зорилго хувьцаа эзэмшигчдийн зорилготой нэгэн адил болж, зөвхөн гэрээний хүрээнд төлөөлөл хэрэгжүүлэн ажиллах байдлыг арилгадаг.
- Ихэвчлэн урамшууллын бодлогод опционыг гурван жилээс бага хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд хувьцааг хямдруулсан үнээр санал болгож болохгүй гэж заасан байдаг.
- Гүйцэтгэх удирдлагад тодорхой хэмжээний урамшуулал олгохоор урьдчилан тохиролцсон бол тогтмол цалин хөлсний багцад оруулан тооцдог.
- Үндсэн цалин нэмэгдүүлэх тохиолдолд бусад урамшуулал, тэтгэмжийг мөн адил нэмэгдүүлэх талаар шийдвэрлэх нь зохистой.

Эх сурвалж. www.corporatefinanceinstitute.com

ФИНТЕК БА РЕГТЕК

2024 ОНЫ ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ 10 КОМПАНИ

8. CURRENT



Current

Орлого: 2023 оны санхүүгийн жилд
50.7 сая ам.доллар

Ажилтан: 51–200

Гүйцэтгэх захирал: Stuart Sopp

Үүсгэн байгуулагдсан: 2015

Current бол Нью-Йорк хотод байрладаг дижитал банк бөгөөд Choice Financial Group-тэй хамтран гар утасны банкны үйлчилгээг санал болгодог. Энэ нь дөрвөн сая гаруй гишүүдэд үйлчилдэг бөгөөд хадгаламжийн урамшуулал, крипто арилжаа, шууд хадгаламжийн сонголт зэрэг төрөл бүрийн бүтээгдэхүүнээр хангадаг. Зөвхөн дижитал загвар ашиглан Current нь америкчуудад дэвшилтэт технологиор санхүүгийн ирээдүйгээ сайжруулахад туслах зорилготой юм. Current нь үйлчлүүлэгчдэдээ санхүүгээ илүү сайн удирдахад нь туслах бүтээгдэхүүнүүдийг санал болгохыг эрмэлздэг.

7. ATOM BANK



Atom bank

Үйл ажиллагааны цэвэр орлого:
65.84 сая фунт стерлинг (82.43
сая ам. доллар) 2023 оны
санхүүгийн жилд

Ажилтан: 500

Гүйцэтгэх захирал: Mark Mullen

Үүсгэн байгуулагдсан: 2013

Их Британийн анхны дижитал банк болох Atom банк нь гар утасны аппликейшн дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг. Английн Дархам хотод төвтэй бөгөөд Испанийн BBVA банкны дэмжлэгийг оруулаад 700 гаруй сая долларын санхүүжилт авсан. Атом банк нь өдөр тутмын үйлчлүүлэгчдэдээ өрсөлдөхүйц ипотека, хадгаламжийн бүтээгдэхүүн, жижиг бизнесүүдэд тохирсон зээлийг санал болгодог. Энтони Томсон, Марк Муллен нарын үүсгэн байгуулсан Atom банк нь дижитал банкууд уламжлалт банкуудыг сорьсон шинэ эриний эхлэлийг тавьсан юм.

6. STARLING BANK



Starling
Bank

Орлого: 453 сая фунт стерлинг
(566 сая ам. доллар) 2023 оны 3
дугаар сар хүртэл

Ажилтан: 2,700

Гүйцэтгэх захирал: Raman Bhatia

Үүсгэн байгуулагдсан: 2014 он

Starling банкныг Энн Боден үүсгэн байгуулсан бөгөөд энэ нь Их Британид анх удаа эмэгтэй хүн банкныг үүсгэн байгуулсан тохиолдол юм. Мөн тэрээр тус байгууллагыг томоохон амжилтанд хүргэсэн. Хэдийгээр тэр ажлаасаа буцсан ч шинэ гүйцэтгэх захирал Раман Бхатиа банкаа эрчимтэй хөгжүүлсээр байна. Старлинг банк нь 4.1 сая данстай бөгөөд 300 гаруй сая долларын санхүүжилт босгожээ. Starling Банк нь ямар ч биет салбаргүй хувийн, хамтарсан, бизнесийн болон евро дансуудыг санал болгодог.

5. MONZO



monzo

Орлого: 2023 оны 2 дугаар сарын
байдлаар 355.6 сая фунт стерлинг
(444.93 сая ам. доллар)

Ажилтан: 2,500

Гүйцэтгэх захирал: TS Anil

Үүсгэн байгуулагдсан: 2015 он

Их Британид төвтэй Monzo нь дэлхийн хамгийн амжилттай банкуудын нэг юм. 2015 оноос эхлэн гар утасны аппликейшн, урьдчилсан төлбөрт дебит карттай болсон Monzo одоогоор 9 сая гаруй хэрэглэгчтэй. Тус банк хямралын үед зардлаа удирдахад нь туслах зорилгоор Monzo Flex-ийг одоо ав, дараа нь төл бүтээгдэхүүнээ гаргасан. Мөн Monzo нь навигац хийхэд хялбар болгох үүднээс гар утасны аппликейшнээ шинэчилж, АНУ-ын зах зээлд гарахын тулд нэмэлт 150 сая фунт стерлинг (187 сая доллар) цуглуулсан байна.

4. N26



Орлого: 236 сая евро (254.3 сая ам. доллар)
2022 оны санхүүгийн жилд

Ажилтан: 1,500

Гүйцэтгэх захирал: Valentin Stalf

Үүсгэн байгуулагдсан: 2013

Германы тэргүүлэгч необанк болох N26-г Валентин Сталф, Максимилиан Тайентал нар 2013 онд үүсгэн байгуулжээ. Европын банкны лицензтэй тэрээр Барселона, Мадрид, Милан, Вена, Парис зэрэг хотууд болон Бразилийн Сан Пауло зэрэг Европ даяар 25 зах зээлд үйл ажиллагаагаа явуулдаг. Саяхан N26 нь N26 криптотод хөрөнгө оруулах үйлчилгээгээ өргөжүүлж 200 хүртэл зоос арилжаалах боломжийг олгосон. Банк нь мөн аюулгүй байдлыг хангах, хурууны хээ таних болон дэвшилтэт 3D Secure технологийг ашиглан үйлчлүүлэгчиддээ итгэлтэйгээр худалдан авалт хийх боломжоор хангаж байна.

2. NUBANK



Орлого: 45 тэрбум ам.доллар 2023 оны санхүүгийн жилд

Ажилчид: 6,000

Гүйцэтгэх захирал: David Velez

Үүсгэн байгуулагдсан: 2013

Латин Америкийн шилдэг дижитал банк болох Nubank-ийг Кристина Жункейра, Давид Велес нар үүсгэн байгуулсан. Nubank нь 70 сая гаруй харилцагчтай бөгөөд инноваци хийх, шинэ бүтээгдэхүүн санал болгохын тулд машин сургалт зэрэг дэвшилтэт технологийг ашигладаг. Зөвхөн дижитал банкны хувьд энгийн, ойлгомжтой, хүн төвтэй шийдэлд төвлөрсөн хэрэглэгчдэд ээлтэй аппликэйшнээр дамжуулан үйлчилгээ үзүүлдэг. Саяхан Nubank дэлхийн зах зээлд өргөжин тэлэхийн тулд Их Британийн финтек Wise компанитай хамтран ажиллав.

3. SOFI



Орлого: 2.12 тэрбум ам.доллар
2023 оны санхүүгийн жилд

Ажилтан: 4,400

Гүйцэтгэх захирал: Anthony Noto

Үүсгэн байгуулагдсан: 2011

Сан Францискогийн тэргүүлэгч дижитал банк болох SoFi нь зээл, зээлийн сонголтоос эхлээд хөрөнгө оруулалтын үйлчилгээ, моргейж зэрэг олон төрлийн өрсөлдөх чадвартай санхүүгийн саналуудыг хүргэх технологийг ашигладаг. Өнөөдөр 8 сая гаруй гишүүнтэй SoFi нь үйлчлүүлэгчдэдээ нэмэлт урамшуулал, өдрийн цагаар үйлчилгээ үзүүлдэг урамшууллын хөтөлбөр боловсруулжээ.

1. REVOLUT



Орлого: 850 сая фунт стерлинг (1.06 тэрбум ам. доллар) 2022 оны санхүүгийн жилд

Ажилтан: 7,500

Гүйцэтгэх захирал: Nikolay Storonsky

Үүсгэн байгуулагдсан: 2015 он

Манай жагсаалтын эхэнд 2015 онд Николай Сторонский, Влад Яценко нарын үүсгэн байгуулсан Revolut бичигдсэн байна. Энэхүү хурдацтай хөгжиж буй дижитал банк одоо 35 сая хэрэглэгч, 500,000 бизнесийн байгууллагуудад үйлчилж байна. Revolut нь валют солилцох, дебит болон виртуал карт, хувьцаа болон криптовалютын арилжаа зэрэг олон төрлийн үйлчилгээг санал болгодог. Тус банк нь сар бүр 250 сая хүртэлх гүйлгээг хийдэг. Санхүүгийн иж бүрэн “супер апп” болохыг зорьж буй Revolut саяхан гар утас дээрх төлөвлөгөөгөө зарлаж, аялал жуулчлалын агентлагуудын B2B төлбөрийг сайжруулах зорилгоор Saber-тэй хамтран ажиллаж, залилангаас урьдчилан сэргийлэх шинэ хиймэл оюун ухааны хэрэгслийг нэвтрүүлсэн.

СУДЛААЧИЙН ИНДЭР

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ БА ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

Б.Батчимэг, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны дарга,
batchimeg_b@frc.mn

Г.Анхзаяа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн,
ankhzaya_g@frc.mn

О.Мичидмаа, СЗХ, ЗЗСХГ, Сэндбоксын албаны мэргэжилтэн,
michidmaa_o@frc.mn

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛД АШИГЛАГДДАГ АРИЛЖААНЫ ПЛАТФОРМУУД

Биржийн зах зээлд үүсдэг хөрвөх чадварын дутагдал болон арилжаа, төлбөр тооцооны үйл ажиллагаанд гардаг хугацааны хоцрогдол зэргийг нөхөн, зах зээлийн үр ашигт байдлыг сайжруулах зорилгоор уламжлалт бус арилжааны системүүд хөгжих болсон. Ашиглагдаж буй технологи, хэрэглээ, зориулалтаас шалтгаалан уламжлалт бус арилжааны системүүд нь улс орон бүрд өөр, өөр цар хүрээ, үйл ажиллагааг хамран ажилладаг бөгөөд нэгдсэн нэг тодорхойлолт онооход хүндрэлтэй байдаг. Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөж буй технологийн дэвшлийг эдгээр уламжлалт бус арилжааны системүүдтэй ашиглаж эхэлсэн бөгөөд цар хүрээ нь өргөжиж байна.

Эдгээр системүүдийн нэг хэрэглээ нь мөнгөний зах зээлд ашиглагддаг. Мөнгөний захын оролцогчдын дунд илүү өргөн хүрээний санхүүжилтийн боломжийг нэг дороос хүртэх, үр ашигтай түргэн шуурхай арилжаанд оролцон хөрвөх чадварын эрэлтээ хангах зэрэг зорилгоор технологийн дэвшлийг ашигласан арилжааны системүүд дэлгэрч байна.

Жишээлбэл АНУ–д уламжлалт бус арилжааны систем (alternative trading system, ATS), Европын холбоо, Англи улсад олон талт арилжааны систем (multilateral trading facility, MTF), Сингапур улсад зохион байгуулалттай арилжааны хэрэгсэл (organized trading facilities) зэрэг нэршлээр явдаг. Энэхүү бүлэгт эдгээр цахим платформуудын хэрэглээ, арилжаалагддаг хэрэгсэл болон зохицуулалтын талаар судалсан болно.

Уламжлалт бус арилжааны систем (alternative trading system)

Уламжлалт бус арилжааны систем (ATS) нь үнэт цаасны худалдагч, худалдан авагч талыг холбосон арилжааны талбар бөгөөд үйл ажиллагааны онцлог, цар хүрээндээ хамааран биржийн зохицуулалтаар эсхүл брокер, дилерийн зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг. АНУ–д уламжлалт бус арилжааны системүүд дээр хувьцаа, хамтын биржээр арилжаалагддаг сангийн эрхүүд, засгийн газрын болон компанийн бондууд, төрөл бүрийн үүсмэл санхүүгийн хэрэгслүүд түгээмэл арилжаалагддаг бол мөнгөний захын хэрэгслүүд бага хувийг бүрдүүлдэг.

Уламжлалт бус арилжааны систем дээрх арилжаа нь биржээс гадуур явагддаг тул арилжаа хаасан цагуудад зах зээлд оролцон, хөрвөх чадвараа хангах, мөн их дүнтэй арилжаа гүйцэтгэхдээ бирж дээрх хувьцааны үнэлгээнд нөлөөлөхгүй байх зорилгоор мэргэжлийн оролцогчид болон институционал хөрөнгө оруулагчид тус системийг их ашиглан гол төлөв хувьцаа, бондын арилжааг гүйцэтгэдэг. Эдгээр шинж чанар, зориулалтаас хамааруулан АНУ–ын зах зээл дэх уламжлалт бус арилжааны системүүд нь дотроо электрон харилцааны сүлжээ (ECN), дарк пүүл (dark pool), кроссинг сүлжээ (crossing network) зэрэг олон төрлүүдэд хуваагддаг.

Зохицуулалт: Уламжлалт бус арилжааны системүүд нь АНУ–ын Үнэт цаас, биржийн хороо (SEC)–ноос зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулдаг. Ингэхдээ уламжлалт бус арилжааны системийн үйл ажиллагааны шинж чанар, арилжааны хэмжээ зэргээс

шалтгаалан биржийн эсхүл брокерын зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулахыг шаарддаг. Брокерын зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулдаг арилжааны системүүдэд нэмэлтээр зах зээлийн шударга байдал, ил тод байдалтай холбоотой шаардлагуудыг тавьдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд блокчэйн технологийг хэрэглэж эхэлснээр уламжлалт бус арилжааны системд явагддаг ил тод бус байдал, бүртгэлтэй холбоотой асуудлууд шийдвэрлэгдэнэ гэж үзэж байна. Уламжлалт бус арилжааны системийн үйл ажиллагаа, технологийн өөрчлөлт зэрэгтэй уялдуулан Үнэт цаас, биржийн тухай хуульд “бирж” – ийн тодорхойлолтыг шинэчлэн тусгаж өгсөн. Бирж нь “үнэт цаасны худалдагч, худалдан авагч нарыг холбосон зах зээлийн талбар, эсхүл биржийн гүйцэтгэдэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг хэрэгслийг хариуцдаг аливаа байгууллага, холбоо эсхүл бүлэг хүмүүсийг хэлнэ” гэж тодорхойлсноор тус зах зээлд шинэ төрлийн арилжааны системийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдсэн.

Олон талт арилжааны систем (multilateral trading facility), зохицуулалттай арилжааны систем (organized trading facility)

Олон талт арилжааны систем (MTF) нь уламжлалт биржийн зах зээлийн хосолмол хэлбэрээр ажилладаг арилжааны талбар бөгөөд цахим системээр дамжуулан худалдагч, худалдан авагчийг холбодог үйл ажиллагаа. Европын холбоо болон Англи улсад энэ төрлийн арилжааны системүүдийг хөрөнгө оруулалтын компаниуд, хөрөнгө оруулалтын банк, эсхүл бие даасан зах зээлийн үйл ажиллагаа эрхлэгч (independent market operator) явуулдаг бөгөөд уламжлалт биржийн зах зээлтэй харьцуулахад тухайн талбараар арилжаалах үнэт цаасанд шаардлага тавьдаггүй, харьцангуй бага зохицуулалтаар ажилладаг. Олон талт арилжааны систем нь тухайн талбараар хийгдэж буй арилжаанд шууд оролцохгүй бөгөөд программ хангамж, технологийг ашиглан худалдагч, худалдан авагчийг холбодог. Олон талт арилжааны систем нь анхлан хувьцааны арилжааг гүйцэтгэх биржийн харилцааны алтернатив хэлбэрээр гарч ирсэн ч явцын дунд үйл ажиллагааны хүрээ нь уламжлалт бус хөрөнгө оруулалтын хэрэгслүүд, мөнгөний захын хэрэгслүүд болон төрөл бүрийн үүсмэл санхүүгийн хэрэгслүүд зэрэг албан ёсны биржийн болон биржийн бус зах зээлд арилжаалагддаггүй санхүүгийн хэрэгслүүд арилжаалагддаг болж өргөжсөн.

Олон талт арилжааны систем нь АНУ–ын уламжлалт бус арилжааны системтэй шинж чанарын хувьд ойролцоо хэдий ч АНУ–ын Үнэт цаасны зах зээлийн хорооноос тавьдаг шаардлага нь Европтой харьцуулахад харьцангуй сул байдаг бөгөөд илүү өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Сүүлийн жилүүдэд Англи Улс болон Европын холбоонд олон талт арилжааны

системээс гадна зохицуулалттай арилжааны систем нэвтэрч буй бөгөөд хувьцаа бус бонд, үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжаалдаг, мөн арилжаанд оролцогчдын захиалгыг зөвшөөрөх, цуцлах эрхтэй байдгаараа олон талт арилжааны системээс ялгаатай.

Зохицуулалт: Европын холбоонд олон талт арилжааны системүүдийг “Санхүүгийн хэрэгслүүдийг арилжаалах зах зээлийг зохицуулах удирдамж (Markets in Financial Instruments Directive, MiFID)”–ын дагуу хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор зохицуулдаг.

Тус зохицуулалтын удирдамжийн дагуу хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гэдэгт дараах үйл ажиллагаанууд хамаарах бөгөөд журмын зохицуулалтад хамаарна.

- Санхүүгийн хэрэгсэл хоорондын арилжааны захиалгыг хүлээн авах, шилжүүлэх;
- Хэрэглэгчийн өмнөөс хөрөнгө оруулалтын захиалга өгөх;
- Өөрийн дансыг хариуцан хөрөнгө оруулалт хийх;
- Багцын удирдлага;
- Хөрөнгө оруулалтын зөвлөгөө;
- Андеррайтинг;
- Төлбөрийн хариуцлагыг үүрэн эсхүл үүрэхгүйгээр санхүүгийн хэрэгсэл гаргах;
- Олон талт арилжааны систем;
- Зохицуулалттай арилжааны систем

Англи Улс нь Европын холбооноос гарсны дараагаар “Санхүүгийн хэрэгслүүдийг арилжаалах зах зээлийг зохицуулах удирдамж II (MiFID II)” гэж боловсруулан мөрдөж эхэлсэн бөгөөд энэ нь Европын холбоонд ашиглагдаж буй удирдамжтай нийтлэг төстэй зохицуулалттай.

Англи Улсын хувьд Олон талт болон зохицуулалттай арилжааны системүүд нь “Зохицуулалттай хөрөнгө оруулалтын бирж”–ийн журмаар зохицуулагддаг бөгөөд тус журмын 16 дугаар бүлэгт олон талт арилжааны системтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг. Үүнд:

Олон талт арилжааны систем нь Англи Улсын аливаа хууль тогтоомжийг дагаж мөрдөх, Европын холбооны Санхүүгийн хэрэгслүүдийг арилжаалах зах зээлийг зохицуулах удирдамжийн арилжааны системтэй холбоотой зохицуулалтыг дагаж мөрдөх;

Английн Санхүүгийн зохицуулах хороонд системийн үйл ажиллагаа, бусад арилжааны систем, бирж, арилжааны

талбаруудтай холбогдож ажилладаг бол түүний талаар, системийн гишүүд, оролцогчид, харилцагчдын талаар дэлгэрэнгүй тайлагнах;

Олон талт арилжааны систем нь хамгийн багадаа идэвхтэй 3 гишүүн, эсхүл хэрэглэгчтэй байж, үнэ тогтоох боломж үүссэн байх, мөн арилжаа, хэлцэлд хэрэглэгчид бие даасан байдлаар оролцох боломжийг хангасан дүрэм, журамтай байх;

Арилжааны системд дараах шаардлагыг хангасан хувь хүн, хуулийн этгээдийг хамруулахаар тусгасан байдаг. Үүнд: Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн хуулийн дагуу зөвшөөрөл авсан хөрөнгө оруулалтын компани, мөн тус хуулийн дагуу зөвшөөрөгдсөн хадгаламжийн үйлчилгээ татдаг зээлийн байгууллага, санхүүгийн зах зээлийн журам, заавар, стандартыг дагаж мөрдөх ёс зүйтэй, санхүүгийн арилжаанд хариуцлагатайгаар оролцож чадах ур чадвар, санхүүгийн нөөц боломжтой хувь хүн эсхүл хуулийн этгээд.

Мөн арилжааны системүүд нь хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийг хөрөнгө оруулалтын үр ашигтай шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах шаардлагатай бөгөөд

хэрэв аль хэдийн бирж, эсхүл биржийн бус зах зээлд гарсан үнэт цаасыг үнэт цаас гаргагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн систем дээр арилжаалсан бол ил тод байдалтай холбоотой хариуцлагыг өөрөө хүлээнэ;

Англи, Европт үйл ажиллагаа явуулдаг олон талт арилжааны системүүд нь уламжлалт санхүүгийн хэрэгслүүдээс гадна уламжлалт бус санхүүгийн хэрэгслүүд, мөнгөний захын хэрэгслүүдийг арилжаалдаг, мөн жижиг дунд, үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан талбарыг ажиллуулдгаараа онцлог юм. Англи улс нь олон талт арилжааны систем жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид өөрсдийн хувьцаа, эсхүл бондоо тухайн систем дээр гаргасан тохиолдолд хэрхэх тухай зохицуулалтыг тусгасан байдаг. Тухайлбал өөр арилжааны системд гаргасан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үнэт цаасыг тухайн компанийн зөвшөөрөлгүйгээр өөрийн систем дээр арилжаалахыг хориглодог. Мөн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үнэт цаасыг арилжаалж буй системүүд нь Английн Санхүүгийн зохицуулагч байгууллагын баталсан “Жижиг дунд үйлдвэрлэлийн зах зээл”-ийн журмыг дагаж мөрдөн ажиллах ёстой.

Шигтгээ. Евро бүсийн хамгийн том репо арилжааны платформ “MTS Market”



MTS MARKET: MTS нь бэлэн мөнгө, репо, своп зэрэг санхүүгийн хэрэгслүүд арилжаалагддаг Европын тэргүүлэгч цахим арилжааны платформ юм. MTS нь мөнгөний зах зээлийн арилжааны систем бөгөөд Европын төрийн өмчийн өрийн үнэт цаасанд төвлөрсөн цахим зах зээл юм.

1988 онд Италийн Сангийн яам хөрөнгө оруулагчдын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, засгийн газрын санхүүжилтийн зардлыг оновчтой болгох зорилгоор Италийн хөрөнгийн бирж (Borsa Italiana) болон дилерүүдийн группийн хамтарсан компани хэлбэрээр байгуулсан. Анх Италийн засгийн газрын бондын цахим арилжааг явуулах зорилгоор байгуулагдаж байсан бол хугацааны явцад гадаад улс орнуудын засгийн газрын үнэт цаасыг арилжаалах, Евро бүсийн засгийн газрын бондыг арилжаалдаг гол зах зээл болж хөгжсөн.

MTS нь институционал хөрөнгө оруулагчид, банкнууд, брокер дилерүүд болон бусад зах зээлд оролцогчдыг холбодог цахим худалдааны платформ болж ажилладаг бөгөөд үйл ажиллагаа явуулж буй улс орныхоо зохицуулалтын хүрээнд, мөн Европын холбооны дүрэм, журмыг дагаж мөрддөг. Эдгээр журмын зорилго нь дижитал салбарын зах зээл, бизнесийн хэрэглэгчид болон платформын үндсэн үйлчилгээний эцсийн хэрэглэгчдэд өрсөлдөхүйц, шударга байдлыг хангах дүрмийг тогтоож, дотоод зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн. Европын холбооны хүрээнд хил дамнанас бизнесийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, дотоодын зах зээлийн зохистой байдлыг хангах, зах зээлд шударга, ижил тэгш байдлыг хангах нь чухал.

35 гаруй жилийн турш MTS нь Европ болон бусад улс орнуудад зохицуулалттай цахим зах зээлээр дамжуулан Европын зах зээлийг дэмжиж, хөрвөх чадвар, арилжааны боломжийг нэмэгдүүлэх, арилжааны үйл явцыг оновчтой болгох зорилгоор хөрөнгө оруулагчдыг нэгтгэн ажиллаж буй. MTS нь хамгийн сүүлийн үеийн арилжааны шийдлийг нэвтрүүлж, өндөр давтамжтай худалдан авах, худалдах саналуудыг холбох, зээлийн болон мөнгөний зах зээлийн оролцогчдын шаардлагыг хангаж, өргөн хүрээний санхүүгийн хэрэгсэл, захиалгын төрлүүдийг санал болгодог.

MTS-ийн хэрэглэгчдэд санал болгодог үйлчилгээ нь MTS Orderbooks, бэлэн мөнгө, репог хамарсан дилер хоорондын бондын зах зээл, MTS үнэт цаас гаргагчийн үйлчилгээ, үүнд анхдагч дуудлага худалдаа, DMO өрийн удирдлага, тайлагнал, MTS BondVision засгийн газрын бондын арилжааны платформ, MTS Data & Analytics өгөгдлийн шинжилгээний үйлчилгээ зэрэг юм. MTS репо нь евро бүсийн репо зах зээлд хөрвөх чадварыг нэмэгдүүлэн, олон улсын болон дотоодын банкнууд, худалдан авагчид, хөрөнгө оруулагчид зэрэг Европ даяар 100 гаруй оролцогчдыг нэгтгэдэг.

Шигтгээ. Евро бүсийн үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны платформ Eurex

Eurex: Eurex нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа, репо арилжааны тэргүүлэгч цахим зах зээл юм. Eurex Repo нь арилжааны банкнууд, хөрөнгийн менежерүүд, төв банкнууд болон бусад санхүүгийн байгууллагуудыг хамруулсан өргөн хүрээний зах зээлд оролцогчдод репо арилжаа хийх боломжийг олгодог.

Тус байгууллага нь цахим арилжааны платформоор дамжуулан репо гүйлгээний ил тод байдал, үр ашиг, эрсдэлийн удирдлагын хэрэгслээр хангаж, санхүүгийн зах зээлийн ерөнхий үйл ажиллагаанд хувь нэмэр оруулдаг. Eurex дээр репо санхүүжилтээс гадна дараах санхүүгийн хэрэгслүүд арилжаалагддаг. Үүнд:

Өмчийн үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex нь хувьцаа болон хувьцааны индексүүд дээр суурилсан фьючерс болон опционы гэрээг гаргадаг. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь зах зээлд оролцогчдод Европ болон бусад бүс нутгуудад бүртгэлтэй үнэт цаас болон хөрөнгийн индексийн үнийн хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх болон таамаглах боломжийг олгодог.

Хүүгийн үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex хүүгийн фьючерс болон опционы гэрээг санал болгодог бөгөөд үүнд Euro Bund, Euro Bobl, Euro Schatz, Euro-BTP фьючерс зэрэг богино болон урт хугацааны хүүгийн түвшин багтана. Эдгээр бүтээгдэхүүнийг хүүгийн түвшний эрсдэлээс хамгаалах, хүүгийн түвшний өөрчлөлтийн талаар таамаглахад ашигладаг.

Тогтмол орлогын үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex нь засгийн газрын бонд, корпорацийн бонд зэрэг тогтмол орлоготой үнэт цаасны фьючерс болон опционы гэрээгээр хангадаг. Эдгээр бүтээгдэхүүн нь зах зээлийн оролцогчдод тогтмол орлогын багцтай холбоотой зээлийн эрсдэл, хүүгийн эрсдэл, хугацааны эрсдэлийг удирдах боломжийг олгодог.

Валютын үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex нь үндсэн валютын хослолууд дээр фьючерс болон опционы гэрээг санал болгож, зах зээлд оролцогчдыг валютын эрсдэлээс хамгаалах, валютын хөдөлгөөний талаар таамаглах хэрэгслүүдээр хангадаг.

Барааны үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эрчим хүчний бүтээгдэхүүн, металл зэрэг бараа бүтээгдэхүүний фьючерс болон опционы гэрээгээр хангадаг. Эдгээр бүтээгдэхүүн нь зах зээлд оролцогчдод түүхий эдийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс хамгаалж, түүхий эдийн үнийн өөрчлөлтөд өртөхөөс сэргийлдэг.

Тогтворгүй байдлын үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex нь хэлбэлзлийн индекс (Volatility index) дээр фьючерс болон опционы гэрээг санал болгож, зах зээлд оролцогчдод зах зээлийн тогтворгүй байдлын өөрчлөлтөөс өөрсдийгөө хамгаалж, таамаглах боломжийг олгодог.

Инфляцын үүсмэл санхүүгийн хэрэгсэл: Eurex нь инфляцын индексүүд дээр фьючерс болон опционы гэрээ байгуулж, зах зээлд оролцогчдод инфляцын эрсдэлээс хамгаалах, инфляцтай холбоотой эрсдэлийг удирдах боломжийг олгодог.

Eurex-ийг Европын үнэт цаас, зах зээлийн газар (ESMA) Германы Холбооны Санхүүгийн Хяналтын Газар (BaFin) зохицуулдаг бөгөөд Eurex нь Европын холбооны дүрэм журам, гишүүн орнуудын хууль тогтоомж, дүрэм, журмыг багтаасан цогц зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр зохицуулалт нь зах зээлийн шударга, ил тод байдал, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдсэн байдаг. Eurex нь Германы Франкфурт хотод байрладаг тул Eurex-ийн үйл ажиллагааг BaFin хянадаг. BaFin нь Eurex-ийг үндэсний дүрэм журмыг дагаж мөрдөх, зах зээлийн нэгдмэл байдал, тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьдаг.

Eurex нь Европын Холбоонд үйл ажиллагаа явуулдаг үүсмэл санхүүгийн хэрэгслийн биржийн хувьд хэд хэдэн зохицуулах байгууллага, эрх бүхий байгууллагуудын зохицуулалтад хамрагддаг. Үүнд: Европын үнэт цаас, зах зээлийн газар (ESMA). ESMA нь үнэт цаасны зах зээлийг хянаж, Eurex зэрэг арилжааны байгууллагуудыг зохицуулдаг Европын холбооны байгууллага юм. ESMA нь ил тод байдал, зах зээлийн шударга байдалтай холбоотой дүрэм зэрэг биржүүдийн үйл ажиллагааны стандарт, удирдамжийг тогтоодог. MiFID II болон түүнийг дагалдах журам болох MiFIR нь Европын холбооны санхүүгийн зах зээлийн зохицуулалтын тогтолцоог бүрдүүлдэг. Энэ нь зах зээлийн бүтэц, ил тод байдал, хөрөнгө оруулагчдыг хамгаалахтай холбоотой шаардлагуудыг багтаасан арилжааны газруудын дүрмийг тогтоодог. Eurex нь Европын холбооны хүрээнд үйл ажиллагаа явуулахын тулд MiFID II/MiFIR шаардлагыг хангасан байх ёстой.

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Олон улс дахь мөнгөний захын зохицуулалт

Олон улсад мөнгөний захын хэрэгслүүд нь электрон арилжааны буюу и-трэйдинг (e-trading) платформуудаар дамжуулан арилжаалагдах хандлага их бий бөгөөд хадгаламжийн сертификат болон репо арилжаа голчлон цахим платформуудаар хийгдэж байна. Мөнгөний зах зээлийн хэрэгслүүдийг анхдагч зах зээлд гаргаж буй банк, санхүүгийн байгууллагууд цахим платформуудыг ашиглан шууд хөрөнгө оруулагчдад санал болгох замаар үр ашигтай, хурдан шуурхай байдлаар хөрөнгө босгох чиг хандлага байна.

Мөнгөний захын хэрэгслийг арилжаалж буй цахим платформуудын зохицуулалт нь улс орон бүрийн зохицуулалтын орчин, платформ дээр арилжаалагдаж буй хэрэгслүүд болон платформын санал болгож буй үйлчилгээ зэргээс шалтгаалан өөр өөр байгаа хэдий ч хөрөнгө оруулалтын үйлчилгээ гэдэг утгаараа үнэт цаасны зохицуулах газар эсхүл санхүүгийн зохицуулагч байгууллагуудын дор зохицуулагдаж байна. Дараах хүснэгтэд хөрөнгийн болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдийг арилжаалдаг цахим платформуудтай холбоотой улс орнуудын зохицуулалтыг хураангуйлан тусгалаа.

Хүснэгт. Олон улс дахь мөнгөний зах зээлийн зохицуулалт

| № | Улс | Зохицуулагч байгууллага | Тусгай зөвшөөрлийн төрөл | Хууль, эрх зүйн зохицуулалт |
|---|----------------|---|--|---|
| 1 | АНУ | Үнэт цаасны зохицуулах хороо (SEC) | Үйл ажиллагааны төрлөөс хамааран уламжлалт бус арилжааны систем (alternative trading systems) эсхүл брокер, дилерийн зөвшөөрөл | Үнэт цаасны зохицуулах хорооноос гаргасан уламжлалт бус арилжааны системийн журам болон үндэсний зах зээлийн системийн багц журмаар зохицуулагддаг. Мөн Санхүүгийн зохицуулагч байгууллага (FINRA)-ын холбогдох дүрэм, журмуудаар зохицуулагддаг. |
| 2 | Европын Холбоо | Гишүүн орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллагууд | Хөрөнгө оруулалтын фирмийн эсхүл олон талт арилжааны системийн зөвшөөрөл | Санхүүгийн хэрэгслийн захирамж болон бусад холбогдох тогтоомжоор зохицуулагддаг. |
| 3 | Англи Улс | Санхүүгийн зохицуулах байгууллага (FCA) | Брокер, дилерийн зөвшөөрлөөр эсхүл зохион байгуулалттай арилжааны хэрэгсэл (organised trading facilities)-ийн зөвшөөрөл | Санхүүгийн зохицуулагч байгууллагаас шаардсан дүрэм, журмууд. Бизнесийн үйл ажиллагааны, зах зээлийн үйл ажиллагааны журам гэх мэт. |
| 4 | Сингапур Улс | Сингапурын төв банк (MAS) | Хөрөнгийн зах зээлийн үйлчилгээний эсхүл албан ёсны зах зээлийн оператор (recognized market operator)-ын зөвшөөрөл | Үнэт цаас фьючерсийн акт болон санхүүгийн зөвлөхийн актын хүрээнд зохицуулагддаг. |
| 5 | Хонг Конг Улс | Үнэт цаас фьючерсийн хороо (SFC) | Үнэт цаасны хэлэлцээр (dealing in securities) болон автомат арилжааны үйлчилгээ (providing automated trading service)-ийн тусгай зөвшөөрөл | Үнэт цаас, фьючерсийн захирамж холбогдох журмуудаар зохицуулагддаг. |
| 6 | Австрали Улс | Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо (ASIC) | Австралийн санхүүгийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл | Корпорацийн тухай хуулийн хүрээнд Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо холбогдох журам, стандартуудаар зохицуулдаг. |

Монгол Улсын зохицуулалтын орчин

Монгол Улсын хувьд Төв банкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд богино хугацаат мөнгөний бодлогын хэрэгслүүдийг арилжаалдаг бөгөөд Төв банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд тус харилцаа нь зохицуулагдан явдаг. Мөн арилжааны банкнууд нь Банкны тухай хуулийн 15.2-т заасны дагуу мөнгөний зах зээл дээр арилжаалагдах нэг жил хүртэлх хугацаатай үнэт цаасыг Монголбанкны зөвшөөрлөөр гаргах буюу худалдаж, худалдан авч, барьцаалж болдог. Харин Төв банк болон арилжааны банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын дунд мөнгөний захын хэрэгслүүд төдийлэн

арилжаалагддаггүй бөгөөд тусгайлан, нарийвчилсан хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй.

Түүнчлэн олон улсад мөнгөний захын хэрэгслүүд нийтлэг арилжаалагддаг цахим арилжааны платформуудтай холбогдох зохицуулалт хараахан бүрдээгүй байгаа бөгөөд биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийнхээ хүрээнд “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ биржийн бус зах зээлийн цахим арилжааны платформ ажиллуулж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн системд хөрөнгийн болон мөнгөний зах зээл хослон ажиллаж зах зээл дэх нөөц хөрөнгө тасралтгүй, үр ашигтайгаар эргэлдэх боломжийг олгодог. Манай улсын хөрөнгийн зах зээл нь гуч гаруй жилийн түүхтэй хэдий ч сүүлийн үед огцом өсөлт, өөрчлөлтийн жилүүд тохиож байна. Харин богино хугацаат санхүүгийн хэрэгслүүд арилжаалагддаг мөнгөний зах зээлийн хувьд бусад хөгжиж буй орнуудын адилаар манай улсад төдийлөн сайн хөгжөөгүй байна. Монгол Улсын мөнгөний зах зээлийн хувьд Төв банкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор гаргадаг хэрэгслүүд болон арилжааны банк хооронд богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээгээ хангахаар арилжаалж буй хэрэгслүүд голчлон арилжаалагдаж байна.

Санхүүгийн болон санхүүгийн бусад салбарын оролцогчдын хувьд мөнгөний захын арилжаанд төдийлөн оролцдоггүй, эдгээр салбарын оролцогчдын дунд мөнгөний зах сайн хөгжөөгүй бөгөөд богино хугацаат санхүүжилтийн бүтээгдэхүүний хэрэгцээ, шаардлага өндөр байсаар байна. Зах зээлийн энэхүү хэрэгцээ, шаардлагад үндэслэн зах зээлд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцлийн зуучлалын платформ нэвтрэн сэндрбоксын орчинд амжилттай туршигдаж байна.

Олон улсад мөнгөний захын хэрэгслүүд нь биржийн бус зах зээлийн зарчмаар голчлон ажиллаж, мөнгөний захын төрөл бүрийн хэрэгслүүд нь цахим арилжааны платформуудаар дамжин арилжаалагдах туршлага сүүлийн жилүүдэд дэлгэрч байна. Гэхдээ зөвхөн мөнгөний захын хэрэгслийг дагнан арилжаалдаг арилжааны платформууд бидний судалгааны хүрээнд олдоогүй бөгөөд төрөл бүрийн бирж болон биржийн бус зах зээл дээр бүртгэлтэй болон бүртгэлгүй үнэт цаас, засгийн газар, компанийн өрийн хэрэгсэл, үүсмэл санхүүгийн хэрэгслүүд мөнгөний захын хэрэгслүүдээс гадна арилжаалагдаж байна. Европын холбоонд ашиглагдаж буй олон талт арилжааны системүүд дээрх мөнгөний захын хэрэгслийн арилжаа бусад улс орнуудтай харьцуулахад

хамгийн өндөр идэвхтэй байна.

Мөнгөний захын хэрэгслүүд арилжаалагдаж буй эдгээр цахим арилжааны платформууд нь уламжлалт биржийн зохицуулалттай харьцуулахад харьцангуй зөөлөн зохицуулалттай бөгөөд платформ дээр арилжаалах үнэт цаасанд нарийвчилсан шаардлага, шалгууруудыг тавьдаггүй. Санхүүгийн зах зээлийн хөгжлөөр тэргүүлэгч АНУ, Англи, Сингапур, Европын холбооны улсууд нь эдгээр төрлийн платформуудад уламжлалт бус арилжааны систем, олон талт арилжааны систем, зохион байгуулалттай арилжааны хэрэгсэл, албан ёсны зах зээлийн оператор зэрэг зөвшөөрлийг олгон холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулж байна. Цахим арилжааны платформуудад хөрөнгө оруулагчийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хамгаалах, зах зээлийн оролцогчдын ижил тэгш, шударга оролцоог хангах зэрэг чиглэлд зохицуулж байна.

Санхүүгийн зах зээлд эрчимтэй нэвтэрч буй технологийн дэвшлийг ашиглан мөнгөний захын арилжааны идэвхилийг нэмэгдүүлэх, зах зээлийн оролцогчид, хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагууд амар хялбар байдлаар мөнгөний захын арилжаанд оролцон, богино хугацаат санхүүжилтийн хэрэгцээгээ хангах, улмаар нийт зах зээлийн үр өгөөж, нөөц хөрөнгийн үр ашигт хуваарилалтыг нэмэгдүүлэхэд мөнгөний захын арилжааны платформ давуу тал олгож байна.

Иймд цаашид цахим арилжааны платформын зохицуулалтын орчныг бүрдүүлэх, мөнгөний захын хэрэгслүүдэд хамаарах нарийвчилсан зохицуулалтыг салбарын холбогдох хууль, журмуудад тусгах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.6-д “санхүүгийн хэрэгсэл” гэж үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, мөнгөний болон зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн бусад санхүүгийн хэрэгслийг ойлгоно гэж заасан байдаг хэдий ч мөнгөний захын хэрэгслийг

хэрхэн, ямар зохицуулалтын хүрээнд хэн, гаргах, арилжих тухай зохицуулалт одоогоор байхгүй байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.13-т “Хуульд заасан санхүүгийн бусад үйл ажиллагаа” гэж заасан байдаг. Иймд санхүүгийн зах зээлд цаашид шинэ төрлийн үйлчилгээ нэвтрэх, санхүүгийн хэрэгслийг арилжаалах цахим арилжааны систем үйл ажиллагаа явуулах эрхийг нээж өгөх үүднээс Санхүүгийн зохицуулах хороо өөрийн эрх, хэмжээний хүрээнд “Уламжлалт бус арилжааны систем”-ийг бүртгэх журмыг батлан, зах зээлд шинээр нэвтэрч буй арилжааны платформын үйл ажиллагаанд хяналт тавих;

- Уламжлалт бус арилжааны системийг хэн ажиллуулах, системд арилжаалах санхүүгийн хэрэгслүүдийг тодорхойлох, системд оролцогч хөрөнгө оруулагчдыг тодорхойлох зэргээр зохицуулалтыг тавих. Тухайлбал АНУ, Европын холбоо, Англи Улсуудад бирж, болон биржийн бус зах зээл дээр арилжаалагддаг үнэт цаас, жижиг дунд, үйлдвэрлэл, гарааны бизнесүүдийн үнэт цаасыг уламжлалт бус арилжааны системд арилжаалахтай холбоотой нэмэлт зохицуулалтууд байдаг. Мөн Англи Улсад энэ төрлийн системд оролцох хэрэглэгч, хөрөнгө оруулагчдад тавигдах шаардлагыг тодорхойлсон байдаг. АНУ-д арилжааны систем дээр арилжаалагдах санхүүгийн хэрэгслүүдийг нийт арилжаанд эзлэх хувиар нь нарийвчлан заасан байдаг.
- Арилжааны систем эрхэлж буй этгээдийн Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх тайлан мэдээ, үйл ажиллагаанд мөрдөж ажиллах холбогдох шаардлага, хариуцлага, мөн системийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг журмаар

тодорхойлж өгөх. Тухайлбал арилжааны системүүдийг улс орнууд зохицуулахдаа худалдагч, худалдан авагч талуудыг хөндлөнгийн нөлөөгүйгээр технологийн тусламжтайгаар шууд тааруулдаг байх, системд оролцогчид нь зах зээлийн журмаар арилжаа явагдах үнэ тогтоох боломжоор хангасан байх зэрэг зохицуулалтыг тусгасан байдаг. Мөн санхүүгийн зохицуулагч байгууллагад тайлагнах мэдээ, тайлан, үзүүлэлтүүдийг нарийвчлан заасан байдаг. АНУ-д бирж болон биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслээс бусад төрлийн санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой мэдээ, тайланг өөрийгөө зохицуулагч байгууллагад мэдээлж, тайлагнадаг жишиг бий.

Зах зээл, технологийн хөгжлийг даган цаашид үнэт цаасны зах зээлд цахим арилжааны системүүд нэвтрэх, ингэхдээ дан ганц мөнгөний захын хэрэгслээр тогтохгүй бусад төрлийн санхүүгийн хэрэгслүүдийг арилжаалах, зах зээлийн хөрвөх чадвар, тасралтгүй байдлыг нэмэгдүүлэх хандлага бий тул дараагийн шинэ боломжуудад нээлттэй зохицуулалтын журам, аргачлалыг боловсруулахад анхааран ажиллах. Тухайлбал АНУ Үнэт цаас, биржийн тухай хуульдаа “бирж”-ийн тодорхойлолтыг шинэчлэн тусгаж өгсөн. Бирж нь “үнэт цаасны худалдагч, худалдан авагч нарыг холбосон зах зээлийн талбар, эсхүл биржийн гүйцэтгэдэг нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг хэрэгслийг хариуцдаг аливаа байгууллага, холбоо эсхүл бүлэг хүмүүсийг хэлнэ” гэж тодорхойлсноор шинэ төрлийн арилжааны системүүд гүйлгээний хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан биржийн зөвшөөрөл авах боломж бүрдсэн байна.

Дээрх зохицуулалтын санал нь зөвхөн энэхүү судалгааны дүгнэлтийн хүрээнд боловсруулагдсан бөгөөд цаашид илүү нарийвчилсан санал, шаардлагатай судалгааг боловсруулах чиглэлд холбогдох байгууллага, нэгжийн албан хаагчидтай хамтран ажиллах саналтай байна.

ЭХ СУРВАЛЖ

- » Adam Hayes (2023) “Money Markets: What They Are, How They Work, and Who Uses Them” <https://www.investopedia.com/terms/m/moneymarket.asp>
- » Christina Malaski (2023) “Money Market Vs. Capital Market: What’s the Difference?” <https://www.investopedia.com/articles/investing/052313/financial-markets-capital-vs-money-markets.asp>
- » Robert Vincent Roosa, RFG Alford, Christiaan Glasz (2023) “Money Market” <https://www.britannica.com/money/topic/money-market>
- » www.mongolbank.mn

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧЭЭС ЗЭЭЛ АВАХДАА ЮУ АНХААРАХ ВЭ?

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй байх;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан банкны харилцах данстай байх;
- Татвар төлөгч байх;
- Татварын нэгдсэн системд холбогдсон кассын машин, хэвлэх төхөөрөмжтэй байх;

Тусгай зөвшөөрөлтэй мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг эндээс шалгана уу.



Зээл, барьцаа болон батлан даалтын гэрээ байгуулахдаа анхаарах зүйлс:

Гэрээг заавал бичгээр байгуулан гарын үсгээр баталгаажуулах бөгөөд дараах нөхцөлийг тусгана:



Зээлийн гэрээ



Талуудын нэр, хаяг / оршин суугаа/ газар ;




дансны дугаар;



нэмэгдүүлсэн хүү байх эсэх (үндсэн хүүгийн 20 хувиас хэтрэхгүй байна);



барьцаа, батлан даалт байх эсэх;



зээлийн хэмжээ болон зээлийн эргэн төлөлтийн хуваарь;



хугацаанаас өмнө эргэн төлөлт хийх нөхцөл;



зээлийн түүнийг аргачлал;

хүүгийн бодох, хэмжээ, тооцох



гэрээ байгуулсан он, сар, өдөр.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Цуврал №39

Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд

Зээлийн гэрээнд холбогдох **барьцаа, батлан даалтын гэрээг** хавсаргах бөгөөд дараах нөхцөлийг тусгасан байна:



Батлан даалтын
гэрээ



Барьцааны гэрээ



Талуудын нэр, хаяг /оршин суугаа/ газар;



Гэрээ байгуулсан он, сар, өдөр;



Үүргийг бүрэн хангах хугацаа;



Зээлийн хэмжээ;



Барьцаалуулагчийн, батлан даагчийн хүлээсэн үүрэг;



Барьцаа хөрөнгө, түүний үнэлгээ.



Тогтоосон хүүгийн дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэнэ үү.



Зээлийн хүүгийн дээд хэмжээ **4.5** хувь

Цахим (финтек)-аар зээлийн бүтээгдэхүүн гаргахгүй, зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ байгуулахгүй.

ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ-ЫН ХОЛБООНЫ НӨӨЦИЙН БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ БУУРУУЛАХ ДОХИО ӨГӨВ.



АНУ-ын Холбооны Нөөцийн банк бодлогын хүүгээ бууруулах дохио хөрөнгө оруулагчдын дунд байгаа ч Төв банкны зүгээс шийдвэр гаргах хугацааг хойшлуулж байна. Энэ нь инфляц саарч, мөнгөний бодлогоо зөөлрүүлэх төлөвтэй байгааг харуулж байгаа ч эдийн засгийн эрсдэлийг тооцон зөв цагийг хүлээх хэрэгтэй байгааг Төв банкны удирдлагын зүгээс анхаарууллаа. АНУ-ын хувьд сүүлийн дөрвөн жилийн хугацаанд анх удаа хэрэглээний үнийн индекс буурсан бөгөөд 2024 оны 6 дугаар сард 5 дугаар сартай харьцуулахад 0.1 хувиар буурчээ.

Эх сурвалж: www.bloomberg.com

УУР АМЬСГАЛЫН САНХҮҮЖИЛТЭД ЖИЛ БҮР 3 ИХ НАЯД АМ.ДОЛЛАР ШААРДЛАГАТАЙ.



БЕЛЕМ, БРАЗИЛ, 7-р сарын 27 – Бямба гарагт АНУ-ын

Сангийн сайд Жанет Йеллен хэлэхдээ “Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн нүүрстөрөгчийн ялгарал багатай эдийн засгийг бий болгоход 2050 он хүртэл жил бүр одоогийн санхүүжилтээс гадна 3 их наяд ам.долларын шинэ хөрөнгө шаардлагатай бөгөөд энэ ялгааг арилгах нь 21-р зууны хамгийн том эдийн засгийн боломж юм.”

Мөн Йеллен Пүрэв болон Баасан гарагт Рио-де-Жанейро хотод болсон “Хорийн бүлэг”-ийн /G20/ орнуудын Сангийн сайд, Төв банкны тэргүүн нарын уулзалтад хэлсэн үгэндээ “Уур амьсгалын өөрчлөлтөд хайхрамжгүй хандах, биологийн төрөл зүйл болон байгалиа алдаж байгаа нь байгаль орчны муу бодлого, эдийн засгийн буруу бодлого юм.”

Чинээлэг орнууд 2022 онд хамгийн өндөр буюу 116 тэрбум ам долларын уур амьсгалын санхүүжилтийг хөгжиж буй орнуудад олгосон ба үүний 40 орчим хувийг олон талын оролцоотой хөгжлийн банк /MDBs/ бүрдүүлжээ. Харин Дэлхийн банк болон Америк Хоорондын Хөгжлийн Банк /IDB/ шинэ зорилго тавин ажиллаж байна.

Эх сурвалж: www.reuters.com

APPLE КОМПАНИЙН ХЯТАД ДАХЬ БОРЛУУЛАЛТ УНАЛТАД ОРСОН ТУЛ IPHONE-ИЙН ШИНЭЧЛЭЛТИЙГ ХИЙМЭЛ ОЮУН УХААНД /AI/ НАЙДАЖ БАЙНА.

Санхүүгийн захирал Лука Маестри Ройтерс агентлагт өгсөн ярилцлагадаа Apple-ийн гурав дах том зах зээл болох Хятадад борлуулалт 6.5 хувиар буурсан өмнөх улиралд 8.1 хувиар буурсан үзүүлэлттэй харьцуулахад бага хувиар буурах хандлага үргэлжилсээр байна. Apple компани Huawei зэрэг орон нутгийн өрсөлдөгчдийн санал болгож буй хямд үнэтэй ухаалаг гар утаснуудтай өрсөлдөхийн тулд Хятад дахь iPhone утсаа 5 сард сонгогдсон загваруудаа 2,300 юань буюу 317 ам.доллар хүртэл хямдруулжээ.

Лондонгийн хөрөнгийн бирж групп /LSEG/-ийн мэдээллээс харахад Apple-ийн улирлын ашиг 1.40 ам.доллар байсан нь Wall Street шинжээчдийн тооцоолсон 1.35 ам.доллароос өндөр байв. Мөн Mac-ийн борлуулалт 7.02 тэрбум ам.доллар хүрэх таамаглалтай харьцуулахад 2.5 хувиар өсөж 7.01 тэрбум ам.долларт хүрчээ. Apple компани 5-р сард хиймэл оюун ухаанд суурилсан шинэ iPad Pro болон илүү том iPad Air загварыг

худалдаанд гаргасны дараа компанийн борлуулалт орлогын iPad хэсэг дэх эзлэх хувь 23.7 хувиар өсөж 7.16 тэрбум ам.долларт хүрчээ. Apple Watch болон AirPods чихэвчний борлуулалт



шинжээчдийн 7.79 тэрбум ам.доллар хүрэх таамаглалаас 2.3 хувиар буурч, 8.10 тэрбум ам.доллар болжээ.

Apple компани ногдол ашгаа 25 цент хэвээр хадгалсан ба санхүүгийн жилийн эхний хагаст Apple компани 110 тэрбум ам.долларын хувьцааг эргүүлэн худалдаж авахаа зарлажээ.

Эх сурвалж: www.reuters.com

ЯПОНЫ ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ НЭГ ХУВЬ ХҮРТЭЛ ААЖМААР ӨСГӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА.

МУМБАЙ/ЭНЭТХЭГ, 7-р сарын 31-ний өдөр Санторигийн гүйцэтгэх захирал Такеши Ниинами Лхагва гарагт Ройтерс Глобал зах зээлийн форумд өгсөн мэдэгдэлдээ Японы төв банк ирэх жилийн дотор бодлогын хүүгээ аажмаар нэмэгдүүлэх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь инфляцаас доогуур хэвээр байгааг онцоллоо.



Энэ нь Японы төв банкнаас сүүлийн 17 жилийн хугацаанд бодлогын хүүгээ анх удаа өсгөж, хасах утгатай байсан бодлогын хүүг 0.25 хувиар нэмэгдүүлэн нэмэх утгатай буюу 0.1 хувьд хүргэсэн юм.

Эх сурвалж: www.reuters.com

2024 ОНЫ 7 ДУГААР САРД ДЭЛХИЙН ХҮНСНИЙ ҮНЭ БУУРСАН ГЭЖ НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭЛЛЭЭ.



ЛОНДОН, 8-р сарын 2. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас дэлхийн хэмжээнд хамгийн их худалдаалагдаж буй хүнсний барааны үнийн индекс 6-р сард 121.0 нэгж байсан бол 7-р сард дунджаар 120.8 нэгж болж буурчээ.

Мөн үр тарианы үнийн индекс 3.8 хувиар буурч сүүлийн дөрвөн жилийн хамгийн доод түвшинд хүрсэн ба дэлхийн зах зээлд үр тарианы экспортын үнэ хоёр сар дараалан буурчээ. Энэ нь Аргентин, Бразил улсуудад ургац хураалт өнгөрсөн жилээс хурдацтай ахиж байгаа болон АНУ-ын ургацын нөхцөл тогтвортой хэвээр байгаатай холбоотой гэж мэдээллээ.

Эх сурвалж: www.reuters.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр

S&P 500 (^GSPC)


5,555.74 -8.67 (-0.16%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 (^N225)


39,470.24 -124.15 (-0.31%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 (^FTSE)


8,167.37 -31.41 (-0.38%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)

17,997.35 -10.22 (-0.06%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

